



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫН ТЭНХИМ

Боржигон
Бямбаагийн ХУЛАН

АРИЛЖААНЫ БАНКНЫ ГАДААД ТӨЛБӨР
ТООЦООНЫ СИСТЕМД ДЭВШИЛТЭТ ТӨЛБӨРИЙН
ХЭРЭГСЛИЙГ НЭВТРҮҮЛЭХ БОЛОМЖ



Мэргэжлийн индекс
041201

Бизнесийн удирдлагын бакалаврын
зэрэг горилсон
Дипломын төсөл

Удирдсан
Т.Туяа /Ph.D/

Улаанбаатар. 2024



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫН ТЭНХИМ

Боржигон
Бямбаагийн ХУЛАН

АРИЛЖААНЫ БАНКНЫ ГАДААД ТӨЛБӨР
ТООЦООНЫ СИСТЕМД ДЭВШИЛТЭТ ТӨЛБӨРИЙН
ХЭРЭГСЛИЙГ НЭВТРҮҮЛЭХ БОЛОМЖ

В Мэргэжлийн индекс
041201

Бизнесийн Удирдлагын Бакалаврын Зэрэг

Горилсон Дипломын Төсөл

Удирдагч: Т.Туяа /Ph.D/
Шүүмжлэгч: Д.Оюунгэрэл /МВА/
..... Э.Тамир /МВА/
..... Т.Оюунгэрэл /Ph.D/

ГАРЧГИЙН ТОВЬЁГ

МЭДЭГДЭЛ.....	i
ТАЛАРХАЛ.....	ii
ТОВЧ ХУРААНГУЙ.....	iii
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ.....	iv
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ.....	v
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ.....	vi
ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ.....	vii
ОРШИЛ.....	1
Сэдвийг сонгосон үндэслэл.....	1
Судалгааны зорилго.....	1
Судалгааны ажлын зорилт.....	2
Практик ач холбогдол ба хэрэгцээ шаардлага.....	2
Сэдвийн судлагдсан байдал.....	3
I БҮЛЭГ. ОНОЛЫН ХЭСЭГ.....	12
1.1 Гадаад төлбөр тооцооны тухай ойлголтууд.....	12
1.2 Валют арилжаа.....	12
1.3 Гадаад гуйвуулга.....	14
1.3 Олон улсын төлбөрийн карт.....	26
Бүлгийн дүгнэлт.....	31
II БҮЛЭГ. САЛБАРЫН СУДАЛГАА.....	32
2.1 Арилжааны банкуудын өнөөгийн байдлын судалгаа.....	32
2.2 Арилжааны банкны гадаад төлбөр тооцоо.....	37
2.3 Олон улс дахь гадаад төлбөр тооцоо (кейс судалгаа).....	42
2.4 CIPS болон CHIPS системийн процесс.....	49
Бүлгийн дүгнэлт.....	53
III БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ.....	54
IV БҮЛЭГ. СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ БА ҮР ДҮН.....	56
4.1 Арилжааны банкуудын гадаад төлбөр тооцооны өнөөгийн байдлыг үнэлэх нь.....	56
4.2 Арилжааны банкны экспертүүдтэй хийсэн ярилцлагын үр дүн.....	61
4.3 Олон улсын кейс харьцуулсан SWOT шинжилгээ.....	70
Бүлгийн дүгнэлт.....	71
ДҮГНЭЛТ.....	72
САНАЛ ЗӨВЛӨМЖ.....	74
НОМЗҮЙ.....	76
ХАВСРАЛТ.....	79

МЭДЭГДЭЛ

Энэхүү дипломын төсөл нь Б.Хулан миний өөрийн бүтээл болохыг баталж байна. Энэхүү бүтээл нь СЭЗИС-ийн оюуны өмч болох бөгөөд дипломын төслийг номын сангаар дамжуулан нийтийн бүтээл болгохыг зөвшөөрч байна.

Нэр: Б.Хулан

Гарын үсэг:

Огноо: 2025.01.14

ТАЛАРХАЛ

Энэхүү бакаларын дипломын ажлыг бичихэд туслалцаа хувь нэмэр үзүүлж зөвөллөгөө өгч удирдан чиглүүлсэн Т.Туяа багшдаа чин сэтгэлээсээ талархал илэрхийлье. Таны цаашдын ажил үйлсэд тань өндрөөс өндөр амжилт хүсье.

Мөн үнэтэй цаг заваа зарцуулан судалгаанд хамрагдсан арилжааны 11 банкны экспертүүдэд гүнээ талархал илэрхийлж байна.

Эцэст нь дипломын ажил бичих эхлэлийг тавьсан хайрт аавдаа талархаж буйгаа илэрхийлье.

Та бүхний дэмжлэг оролцоогүйгээр би энэхүү судалгааны ажлаа хийж гүйцэтгэх боломжгүй байлаа.

ТОВЧ ХУРААНГУЙ

Энэхүү дипломын ажил нь Монгол Улсын гадаад төлбөр тооцооны системийг инновацилаг төлбөрийн шийдлээр баяжуулж, илүү хүртээмжтэй, үр ашигтай болгох боломжийг судлах зорилготой. Өнөөгийн нөхцөлд Монгол Улс Society for Worldwide Interbank Financial Telecommunication (SWIFT) зэрэг олон улсын санхүүгийн сүлжээг ашиглан гадаад төлбөр тооцоог гүйцэтгэдэг ч геополитикийн нөхцөл байдлаас үүдэн тодорхой эрсдэлтэй нүүр тулж байна. Тухайлбал, Европын холбоо болон АНУ-ын зүгээс ОХУ руу SWIFT-ээр хийсэн гүйлгээнд өндөр ач холбогдол өгч дайны санхүүжилттэй холбон үзэж гүйлгээх удаашруулах, царцаах өндөр эрсдэлтэй байгаа нь Монгол Улс тог цахилгаан, нефтийн хомсдол цаашлаад инфляцид ч нөлөөлж болохоор сөргөөр нөлөөлж байна.

Энэхүү судалгаа нь олон улсын төлбөр тооцооны бусад системүүдийг судалж нэвтрүүлснээр эдийн засгийн аюулгүй байдал, комплайнсын асуудалтай хэрхэн нийцэж буйг судлахад чиглэгдэж байна.

Түлхүүр үгс: *Арилжааны банк, гадаад төлбөр тооцоо, SWIFT, корреспондент банк, CIPS, CHIPS*

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 0.1 Дотоодын судлагдсан байдал.....	3
Хүснэгт 0.2 Гадаадын судлагдсан байдал	9
Хүснэгт 1.1 Western Union-оор дамжуулан төлбөр тооцоо хийх процесс	20
Хүснэгт 1.2 MoneyGram-аар дамжуулан төлбөр тооцоо хийх процесс.....	22
Хүснэгт 1.3 Инкассын төрөл.....	24
Хүснэгт 1.4 Цахим хэтэвчний төрлүүд.....	28
Хүснэгт 2.1 Арилжааны банкны гадаад гуйвуулга хийдэг валют болон корреспондент банкууд.....	37
Хүснэгт 2.2 Арилжааны банкнуудын SWIFT (GPI) нэвтрүүлсэн байдал.....	39
Хүснэгт 2.3 Банкнуудын гадаад төлбөр тооцооны төрөл нэвтрүүлсэн байдал	40
Хүснэгт 3.1 Судалгааны арга зүй	54
Хүснэгт 4.1 Танай банкинд эдгээрээс гадаад төлбөр тооцоотой холбоотой ямар асуудлууд байгаа вэ?	57
Хүснэгт 4.2 Олон улсын карттай холбоотой ямар асуудал гарч байсан бэ?.....	58
Хүснэгт 4.3 Арилжааны 10 банкны экспертүүдтэй хийсэн ярилцлагийн үр дүн.....	61

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1 SWIFT	14
Зураг 1.2 SWIFT системээр гуйвуулга хийх процесс	17
Зураг 1.3 Корреспондент банкны бүтэц.....	19
Зураг 1.4 Western union.....	20
Зураг 1.5 Moneygram.....	21
Зураг 1.6 Аккретивийн үе.....	23
Зураг 1.7 Инкассын үе шат.....	25
Зураг 1.8 Apple pay.....	28
Зураг 1.9 Googlepay.....	28
Зураг 1.10 Samsungpay.....	28
Зураг 1.11 Paypal	29
Зураг 1.12 Wechatpay	29
Зураг 1.13 Alipay	29
Зураг 2.1 Арилжааны банкнуудын гадаад актив, пассив	33
Зураг 2.2 Монгол Улсын нийт импорт, экспортын хэмжээ (хувиар).....	34
Зураг 2.3 Монгол Улсын экспортын хэмжээ (улсаар).....	34
Зураг 2.4 Монгол Улсын импортын хэмжээ (улсаар)	35
Зураг 4.1 Танай банкинд гадаад төлбөр тооцоотой холбоотой ямар асуудлууд байгаа вэ?	57
Зураг 4.2 SWIFT гүйлгээтэй холбоотой ямар асуудлууд гарч байсан бэ?	59
Зураг 4.3 SWIFT-ээр хийсэн гүйлгээний тоо	60
Зураг 4.4 Арилжааны 9 банкны гадаад гуйвуулга хийдэг улс хувиар (2023 он)	61

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт А Судалгааны асуулга	79
Хавсралт В Арилжааны банкуудын корреспондент банкны харилцаа болон гадаад гуйвуулга хийх боломжтой валют.....	81
Хавсралт С SWIFT-ээр дамжуулан төлбөр тооцоо хийх үе шат.....	86
Хавсралт D Корреспондент банкаар дамжуулан төлбөр тооцоо хийх процесс	88
Хавсралт E Монгол улсын гадаад төлбөр тооцооны гүйлгээний төрөл.....	89
Хавсралт F“А” банкны SWIFT-ээр дамжуулан гүйлгээ хийсэн мэдээлэл (Сая ам. доллараар).....	90
Хавсралт G Ярилцлагийн аргаар авсан арилжааны банкны гадаад гуйвуулга хийдэг улс (хувиар).....	91

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

Нэршил товчлол	Жагсаалт
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ЕХ	Европын Холбоо
ЖДҮ	Жижиг, Дунд Үйлдвэрлэл
ДНБ	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
МУТСТ	Монгол Улсын Тогтвортой Санхүүжилтийн Тайлан
НУБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ПОС	Пос Терминал
ТТҮҮБ	Төлбөр Тооцооны Үндэсний Үйлчилгээний Байгууллага
ҮТС	Үндэсний Төлбөрийн Систем
ФАТФ	Санхүүгийн Ажиллагааны Зөвлөмжийн Байгууллага
ФТАФ	Санхүүгийн Терроризмтой Тэмцэх Ажиллагааны Форум
ОХУ	Оросын Холбооны Улс
B2B	Business-to-Business
BIC	Bank Identifier Code
BIS	Bank for International Settlements
BRI	Belt and Road Initiative
BRICS	Brazil, Russia, India, China, South Africa
CBDC	Central Bank Digital Currency
CIPS	Cross-Border Interbank Payment System
CLS	Continuous Linked Settlement
CSP	Customer Security Programme
DBS	Development Bank of Singapore
EMV	Europay, Mastercard, and Visa (payment standard)
GPI	Global Payment Innovation
ICC	International Chamber of Commerce
ICBC	Industrial and Commercial Bank of China
IMF	International Monetary Fund

IPS	Instant Payment System
ISO	International Organization for Standardization
MAS	Monetary Authority of Singapore
MEPS+	MAS Electronic Payment System Plus
MST	Magnetic Secure Transmission
NFC	Near Field Communication
NSO	National Statistical Office
OTP	One-Time Password
P2P	Peer-to-Peer
QR	Quick Response (code)
RTGS	Real-Time Gross Settlement
SEPA	Single Euro Payments Area
SGQR	Singapore Quick Response (code)
SIPN	Secure IP Network

ОРШИЛ

Сэдвийг сонгосон үндэслэл

Монгол Улс 2019 онд Олон улсын санхүүгийн ажиглалтын байгууллага (FATF)-д орсон нь санхүүгийн салбарт олон улсын хяналт, шалгалт нэмэгдэж, улмаар гадаад төлбөр тооцоонд бэрхшээл үүссэн ч 2020 оны 10-р сард саарал жагсаалтаас гарснаар гадаад санхүүгийн харилцаагаа сэргээх боломжтой болсон. Өнөөгийн байдлаар Монгол Улсын гадаад төлбөр тооцооны системд SWIFT болон бусад олон улсын сүлжээг ашиглан гүйцэтгэдэг. Гэвч Монгол Улсын эдийн засаг эрдэс баялгийн экспортод ихээхэн хамааралтай бөгөөд энэ нь үнийн хэлбэлзлээс шалтгаалж гадаад төлбөр тооцооны системд дарамт учруулж байна. Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2023 онд 7.2%-аар өссөн бол 2024 оны 3-р улирлын байдлаар 5.3%-ийн өсөлттэй байх төлөвтэй байна. Энэ нь эдийн засгийн өсөлт саарах хандлагыг илтгэж, нэмэлт сорилтуудыг үүсгэж болзошгүйг харуулж байна.

Дэлхий дахинд өрнөж буй геополитикийн зөрчил, ялангуяа ОХУ-ын Украинтай хийж буй зөрчилдөөнөөс үүдэн Монгол Улсын гадаад төлбөр тооцоо дахин хүндрэлтэй нөхцөлд орж эхэлсэн. SWIFT системийг ашиглах нь ОХУ-тай ойрын эдийн засгийн харилцаатай Монгол Улсад эрсдэл учрах нөхцөл байдал үүсээд байна. Европын холбоо болон АНУ-ын зүгээс SWIFT системийн хэрэглээг дайны санхүүжүүлжтэй холбон үзэж, хориг тавих боломжтой гэж үзэж байгаа нь гадаад төлбөр тооцоонд өндөр эрсдэлтэй нөхцөл байдал үүсгэж байна. Иймд Монгол Улс гадаад төлбөр тооцооны системээ найдвартай, хүртээмжтэй болгохын тулд инновацилаг төлбөрийн шийдлүүдийг олох шаардлагатай болж байна.

Энэхүү дипломын ажил нь эдгээр хүчин зүйлсийг харгалзан үзэж гадаад төлбөр тооцооны олон улсад хэрэглэгдэж буй хэрэгслүүдийг судалж, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр ямар арга зам хэрэгжүүлэх боломжтойг судласан болно.

Судалгааны зорилго

Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын арилжааны банкны гадаад төлбөр тооцооны системийг сайжруулах, инновацилаг шийдлээр хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг тодорхойлох юм.

Судалгааны ажлын зорилт

- Гадаад төлбөр тооцооны хэрэгслүүдийн онол, аргазүйг судлах
- Арилжааны банкны гадаад төлбөр тооцооны өнөөгийн байдлын судалгаа хийх, дүн шинжилгээ хийх
- Олон улсын кейс судалгаа хийж дүн шинжилгээ хийх
- Сайжруулах арга зам зөвлөмж боловсруулах

Практик ач холбогдол ба хэрэгцээ шаардлага

Монгол улсын гадаад төлбөр тооцооны ихэнхи хувь нь SWIFT системээр дамжин явдаг ба 50%-аас дээш хөрш хоёр улс экспорт, импортын дийлэнхи хувийг бүрдүүлж байна. Өнөөгийн нөхцөлд Монголын арилжааны банкнуудын хэрэгжүүлж буй гадаад төлбөр тооцооны туршлага, жишээн дээр тулгуурлан шинжилгээ хийж олон улсын төлбөрийн системийг Монголд нэвтрүүлэх эдийн засгийн хүртээмж, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх боломж, эрсдэл, сул талуудыг тодорхойлох шаардлагатай байна. Дипломны ажлаар Монгол Улсын гадаад төлбөр тооцооны системийг хөгжүүлэхэд чиглэсэн практик шийдлүүдийг олоход чиглэгдсэн ба энэхүү судалгаагаар олон улсын системийг үр дүнтэй нэвтрүүлэх арга замыг боловсруулж санал дэвшүүллээ.

Сэдвийн судлагдсан байдал

Дотоодын судлагдсан байдал

Монгол улсад судлагдсан байдлыг нэгтгэвэл арилжааны банкны төлбөр тооцооны үйл ажиллагааг сайжруулах, эрсдэлийг бууруулах, олон улсын худалдаа болон дотоодын төлбөр тооцооны үйлчилгээг илүү үр дүнтэй болгох чиглэлээр судалгаа хийгдсэн байна.

Хүснэгт 0.1 Дотоодын судлагдсан байдал

1	Судалгааны ажлын нэр:	Төлбөр тооцооны хэрэгслийг хөгжүүлэх судалгаа
	Судлаачийн нэр, он:	А.Азжаргал, 2018
	Судалгааны зорилго:	Төлбөр тооцооны хэрэгслийн хэрэглээний чиг хандлагыг судалж, Монгол улсад хамгийн оновчтой хэрэгсэл аль болохыг тодорхойлж, түүний хэрэглээг нэмэгдүүлэхэд төлбөрийн системийн оролцогчдын хувьд хэрхэн дэмжих талаар судлах зорилго оршино.
	Судалгааны арга зүй:	Энэхүү судалгааны арга зүйд хэрэглэгчдийн хандлагын судалгааг 8 үндсэн асуулттай 99 хүнээс авсан байна.
	Судалгааны үр дүн:	Дэлхийн нийтийн чиг хандлага банкнууд FinTech компанитай хамтран ажиллаж өртгөө бууруулж , хэрэглэгчийн хандлагын судалгаа болон бүтээгдэхүүний хөгжүүлэлтэд анхаарч байна. Харин манай улсын хувьд харьцангуй жижиг зах зээлтэй учир банкнууд тус тусдаа бүтээгдэхүүн хөгжүүлэх нь хэтэрхий өндөр зардалтай учир дэлхийн чиг хандлагыг дагах нь манай улсын хувьд өндөр ач холбогдолтой байна гэсэн үр дүн гарсан.
2	Судалгааны ажлын нэр:	Арилжааны банкны свифт сүлжээнд хийгдэх төлбөр тооцооны эрсдлийг бууруулах боломж арга зам
	Судлаачийн нэр, он:	Э.Тамир, 2018

	Судалгааны зорилго:	Арилжааны банкнуудын свифт сүлжээнд хийгдэж буй олон улсын төлбөр тооцооны эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг бууруулах боломж, арга замыг тодорхойлоход уг судалгааны ажлын зорилго оршино.
	Судалгааны арга зүй:	Энэхүү судалгаа нь Монголын арилжааны банкнууд мөнгө угаалтын эсрэг ямар бодлого, журам ашигладаг эсэхийг ярилцлагын аргаар тодорхойлж, арилжааны банкнуудад системээр дамжин ямар төрлийн кейс гарч байгаа талаар тандалтын судалгаа болон анкетийн судалгаа хийсэн байна.
	Судалгааны үр дүн:	Арилжааны банкнуудын хувьд ФТАФ-ын зөвлөмж, мөнгө угаалт болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаар бүрэн судалж эрсдэлийг бууруулах арга замыг макро болон микро түвшинд ангиллаж оролцогч талуудын гүйцэтгэх ажил, түүний хэрэгжих хугацаа, үр дүн зэргийг судалгаанд нарийн заасан байна.
3	Судалгааны ажлын нэр:	Арилжааны банкуудын олон улсын худалдаа, төлбөр тооцооны эрсдэлийн удирдлагыг сайжруулах боломж, арга зам
	Судлаачийн нэр, он:	Б.Буянцэцэг, 2017
	Судалгааны зорилго:	Арилжааны банкны олон улсын худалдаа, төлбөр тооцоотой холбоотой асуудлуудыг илрүүлж, эрсдэлийн удирдлагыг сайжруулах арга замыг тодорхойлж, зөвлөмж өгөх зорилготой.
	Судалгааны арга зүй:	Энэхүү судалгаа нь статистикийн тоон мэдээлэл болон баримт ашиглан иш татахдаа олон улсын байгууллагуудын журам, зөвлөмжийг ашигласан. Мөн кейс шинжилгээ болон, асуулга анкетын болон ярилцлагын аргыг ашиглан хийсэн.
	Судалгааны үр дүн:	Судалгааны үр дүнгээс үзэхэд арилжааны банкнуудад сүүлийн нэг жилийн хугацаанд тухайн

		банкны харилцагч болон харилцагч биш этгээд сэжигтэй байж болзошгүй гүйлгээ хийхийг завдсан тохиолдол байна. Энэ нь манай улс МУТСТ үйл ажиллагааг сайжруулах, урьдчилан сэргийлэх шаардлагатай болохыг харуулж байна.
4	Судалгааны ажлын нэр:	Арилжааны банкны төлбөр тооцооны үйлчилгээг сайжруулах арга замууд.
	Судлаачийн нэр, он:	Ц.Алимаа, 2017
	Судалгааны зорилго:	Төлбөр тооцооны чиглэлд дижитал сувгийг цаашид хэрхэн хөгжүүлэх, удирдан зохион байгуулах талаар арилжааны банкнуудад зөвлөмж боловсруулах.
	Судалгааны арга зүй:	Энэхүү судалгаа нь асуулга цаасаар болон цахимаар боловсруулж түүн дээрээ шинжилгээ хийсэн байна.
	Судалгааны үр дүн:	Банкны салбарын цаашдын чиг хандлага нь бусад санхүүгийн бус байгууллагууд болон технологийн компаниудтай хамтран хөгжинө гэж үзэж байгаа ба технологи болон дэд бүтцийн хувьд дижитал шилжилтэд бэлэн байна гэж үзжээ.
5	Судалгааны ажлын нэр:	Арилжааны банкны цахим үйлчилгээнд ‘Төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэгч байгууллага’-ын оролцоог нэвтрүүлэх нь
	Судлаачийн нэр, он:	Г.Анхзүсэм, 2017
	Судалгааны зорилго:	Арилжааны банкны цахим үйлчилгээний өнөөгийн байдал, үр ашгийг тодорхойлж, цахим үйлчилгээний дэд бүтцийг бий болгох боломжит хувилбарыг санал болгоход судалгааны ажлын зорилго оршино.
	Судалгааны арга зүй:	Энэхүү судалгаа нь банкны цахим үйлчилгээний олон улсын кейс судалгаа, өнөөгийн байдлыг тодорхойлох судалгаан дээр суурилсан. Менежментийн шинжлэх ухааны мэдээллийг олборлох, кейс судалгаа боловсруулах аргыг

		<p>өргөн хэрэглэсэн болно. Судалгааг явуулахдаа харьцуулалт, ажиглалт, кейс шинжилгээ, чанарын ба тоон шинжилгээний аргуудыг голчлон ашигласан байна.</p>
	Судалгааны үр дүн:	<p>Цахим үйлчилгээний бизнесийн үйл ажиллагаанд хийгдэж байгаа ТТҮҮБ-д шилжүүлэх боломжтой зардлын хэмжээ нь нэгж банкны хувьд 580 сая орчим төгрөгийн хэмнэлт хийх боломжийг бий болгож байна. Энэ нь онолын хэсэгт судалсан гадаад улс орны туршлага, кейс судалгааны дагуу ТТҮҮБ-ны давуу талыг арилжааны банканд бий болгож байна.</p>
6	Судалгааны ажлын нэр:	<p>Гадаадын банкны үйл ажиллагааг Монголд нэвтрүүлэх боломжит хувилбарыг үнэлэх нь</p>
	Судлаачийн нэр, он:	<p>Г.Дэлгэр, 2019</p>
	Судалгааны зорилго:	<p>Гадаадын банк Монгол улсад орж ирснээр эдийн засаг болон бизнесийн орчинд үзүүлэх нөлөөллийг тодорхойлж, гадаадын банк нэвтрэх хувилбарыг үнэлэх.</p>
	Судалгааны арга зүй:	<p>Энэхүү судалгаа нь гадаадын банк зах зээлд нэвтэрснээр эдийн засаг болон бизнесийн орчинд хэрхэн нөлөөлөхийг тоон болон чанарын судалгаан дээр тулгуурлан хийгдсэн байна.</p>
	Судалгааны үр дүн:	<p>Эдийн засаг болоод бизнесийн орчинд үзүүлэх нөлөөг нийтэд нь дүгнэвэл, дотоодын банкны салбараа тогтвортой, ашигт ажиллагаа хэвийн, хууль эрх зүйн орчин олон улсын стандарт журмын дагуу байж чадах хэмжээнд сайжруулах шаардлага байгааг ажиглалаа. Гадаадын пассивын зээлийн хүү буурахад шууд нөлөөлөхгүй гэсэн үр дүн гарсан учир гадаадын банк орж ирээд зээл эх үүсвэр нэмэгдсэн ч ойролцоо нөхцөл байдалд байна гэж таамаглаж байна. Иймд зөвхөн зээлийн хүү банк санхүүгийн салбарыг нийтэд нь үр</p>

		өгөөжтэй, өсөлт дэвшилттэй байлгах хүчин зүйлүүдийг харж байж гадаадын банкнуудыг нэвтрүүлэх нь чухал болов уу.
7	Судалгааны ажлын нэр:	Арилжааны банкуудын корреспондент банкны сүлжээг нэмэгдүүлэх арга зам
	Судлаачийн нэр, он:	Б.Цолмон, 2018
	Судалгааны зорилго:	Монголын банкны салбарт олон улсын төлбөр тооцоог дамжуулах үндсэн дэд бүтэц болох корреспондент банкны сүлжээ буурах болсон шалтгааныг тодорхойлох, түүнээс урьдчилан сэргийлэх боломж, арга замыг тодорхойлоход судалгааны ажлын зорилго оршино.
	Судалгааны арга зүй:	Судалгааны ажилд арилжааны банкнуудаас асуулга судалгаа байдлаар мэдээлэх үүрэгтэй этгээдүүдээс ярилцлагын байдлаар судалгаа авсан байна.
	Судалгааны үр дүн:	Дотоодын банкнууд нь зөвхөн тохиолдолд суурилсан сэжигтэй гүйлгээг илрүүлэн мөшгөхөөс гадна тохиолдлуудын цуваанд шинжилгээ хийж харилцагчдын сэжигтэй үйл ажиллагааг илрүүлдэг, илрүүлсэн мөшгөхөөс гадна тохиолдлуудын цуваанд шинжилгээ хийж харилцагчдын сэжигтэй үйл ажиллагааг илрүүлдэг, илрүүлсэн мэдээллээ зохицуулагч байгууллага руугаа мэдээлэн тайлагнадаг байх нь корреспондент банкны үнэлгээнд сайнаар нөлөөлж, улмаар кореспондент банкны харилцаа өргөжин тэлэхэд ач холбогдолтой байна.
8	Судалгааны ажлын нэр:	SWIFT ашиглан компаний мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулах боломж,туршлага,арга зам
	Судлаачийн нэр, он:	Л.Чинзориг, 2020
	Судалгааны зорилго:	Төлбөр тооцооны системийн өнөөгийн байдлыг судалж, компанийн мөнгөн хөрөнгийн удирдлагыг

	технологи болон улсын туршлага дээр тулгуурлан сайжруулан боломж, арга замыг тодорхойлоход энэхүү судалгааны зорилго оршиж байна.
Судалгааны арга зүй:	Судалгааны ажилд бичиг баримтын шинжилгээний арга, асуулгын арга, ганцаарчилсан стандарчилалагдаагүй ярилцлагын аргуудаар судалгааны өгөгдөл цуглуулж дүгнэлт шинжилгээ хийх арга зүйг ашигласан байна.
Судалгааны үр дүн:	Монгол Улс нь SWIFT сүлжээний талаар зөвхөн банкны ашигладаг нэгэн хэрэгсэл байдлаар ашигладаг байна. Мөнгөн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх тал дээр бусад судлаачдын ажлаас нэгтгэн үзэхэд олон улсын түшинд менежмент хийх нь дутмаг байсаар байна. Энэ нь Монголд үйл ажиллагаа явуулж байгаа бизнесийн компаниудын 86 хувь нь жижиг дунд үйлдвэрлэлийн хэмжээнд байгаа нь (ЖДҮ тухай хуулийн төслийн танилцуулга. 2017) нөлөөлөх хүчин зүйл болж байна.

Эх сурвалж: Судлаачийн эмхтгэл

Эдгээр судалгаанд SWIFT сүлжээний эрсдэлийг бууруулах, төлбөр тооцооны хэрэгслийг хөгжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах, мөн эрсдэлийн удирдлагын арга хэмжээг үр ашигтай болгох боломжуудыг онцолсон нь салбарын цаашдын хөгжлийг дэмжихэд үнэтэй хувь нэмэр оруулжээ.

Гадаадын судлагдсан байдал

Олон улсад судлагдсан байдлыг нэгтгэвэл гадаад төлбөр тооцооны системийн үр ашиг, уялдаа холбоог сайжруулах чиглэлээр судалгаа, шинжилгээний ажлууд хийгдсэн байна.

Хүснэгт 0.2 Гадаадын судлагдсан байдал

1	Судалгааны ажлын нэр:	Гадаад төлбөр тооцоог сайжруулах арга замууд
	Судлаачийн нэр, он:	Олон улсын төлбөрийн банк (BIS),2022
	Судалгааны зорилго:	Энэхүү судалгааны зорилго нь олон улсын төлбөрийн хурд, зардал, ил тод байдлыг олон талт хамтын ажиллагааны тусламжтайгаар сайжруулах.
	Судалгааны арга зүй:	Төрөл бүрийн бүс нутгийн төлбөрийн системүүдийг харьцуулсан судалгаа, үр ашгийг нөлөөлөх хүчин зүйлүүдийг шинжилж судалгаа хийсэн.
	Судалгааны үр дүн:	Энэхүү судалгааны үр дүнд ISO 20022 гэх зэрэг стандартчилсан систем болон дижитал валютуудыг ашиглах нь төлбөрийн зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлнэ. Энэ нь орнуудын дунд харилцан уялдаатай, стандартжуулсан прокол бий болгох боломжтой болохыг харуулж байна.
2	Судалгааны ажлын нэр:	Олон улсын төлбөрийн олон талт платформуудыг судлах нь
	Судлаачийн нэр, он:	Олон улсын валютын сан (IMF),2023
	Судалгааны зорилго:	Энэхүү судалгааны зорилго нь олон талт платформуудын тусламжтайгаар олон улсын төлбөр тооцооны үр ашиг, хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг судлахад оршино.
	Судалгааны арга зүй:	Олон улсын төлбөрийн платформуудын кейс судалгаа, олон бүс нутгийн оролцогчдоос чанарын өгөгдөл цуглуулж судалгаа хийсэн.

	Судалгааны үр дүн:	Судалгааны үр дүнд олон талт платформууд нь илүү үр ашигтай төлбөрийн системийг дэмждэг бөгөөд төв банкнуудын хяналт, хамтын ажиллагаа чухал. Эдгээр платформууд нь завсрын байгууллагуудаас хамааралгүй байх боломжийг олгож, жижиг орнуудын зардлыг бууруулдаг болохыг харуулж байна.
3	Судалгааны ажлын нэр:	Хөгжиж буй орнуудад дижитал төлбөрийн уялдаа холбоо
	Судлаачийн нэр, он:	Дэлхийн банк, 2021
	Судалгааны зорилго:	Энэхүү судалгааны зорилго нь хөгжиж буй орнуудад дижитал дижитал төлбөрийн системийн уялдаа холбоо эдийн засгийн хүртээмжид хэрхэн нөлөөлж буйг үнэлэхэд оршино.
	Судалгааны арга зүй:	Дижитал төлбөрийн сүлжээтэй бүс нутгуудад хээрийн судалгаа, эдийн засгийн загварчлалд суурилан судалгаа хийсэн.
	Судалгааны үр дүн:	Судалгааны үр дүнд дижитал хэтэвч болон уламжлалт банкны системийн уялдаа холбоог хангах нь хөдлөх зардлыг бууруулж, ялангуяа бага орлоготой бүс нутгуудад хүртээмжийг нэмэгдүүлж байна.
4	Судалгааны ажлын нэр:	Олон улсын төлбөрийн системүүдэд ISO 20022-г хэрэгжүүлэх нь
	Судлаачийн нэр, он:	Worldline, 2021
	Судалгааны зорилго:	Энэхүү судалгаа нь ISO 20022 стандартыг нэвтрүүлснээр олон улсын төлбөрийн хурд, зардлыг сайжруулах боломжийг судлах зорилготой.
	Судалгааны арга зүй:	Олон улсын төлбөр тооцоонд ISO 20022 стандартыг хэрэгжүүлэх техник шинжилгээ хийж судалгаа хийсэн.
	Судалгааны үр дүн:	Үр дүнд нь ISO 20022-г хэрэгжүүлснээр гадаад төлбөр тооцооны системийн харилцан уялдаа

		холбоог сайжруулж, орон нутгийн болон гадаад төлбөрийн дэд бүтцүүдийн уялдааг нэмэгдүүлэх замаар зардлыг бууруулах боломжтой гэж гарсан.
5	Судалгааны ажлын нэр:	Төв банкны дижитал валютын (CBDC) гүйцэтгэх үүрэг
	Судлаачийн нэр, он:	Европын төв банк, 2022
	Судалгааны зорилго:	Энэхүү судалгааны зорилгод олон улсын төлбөр тооцооны үр ашиг аюулгүй байдлыг сайжруулахад CBDC-г хэрэглэх боломжийг судлахад оршино.
	Судалгааны арга зүй:	Дижитал валютын төслүүдийн харьцуулсан шинжилгээ, олон улсын туршлагыг харуулсан кейс судалгаан дээр үндэслэж судалгаагаа хийсэн.
	Судалгааны үр дүн:	Судалгааны үр дүнд CBDC нь валютын солилцооны зардлыг бууруулж, төлбөрийн хурдыг нэмэгдүүлэх боломжтой ч олон улсын хэмжээнд үр дүнтэй байхын тулд нийтлэг зохицуулалтын орчин хэрэгтэй байна.

Эх сурвалж: Судлаачийн эмхтгэсэнээр

Эдгээр судалгаанд төлбөр тооцооны олон талт платформуудыг ашиглах боломж, хөгжиж буй орнуудад дижитал төлбөрийн уялдаа холбоог хангах арга замууд, олон улсын төлбөрийн системд шинэ стандартууд, тухайлбал ISO 20022-г хэрэгжүүлэхийн ач холбогдлыг онцолсон байна. Эдгээр нь төлбөр тооцооны дэд бүтцийг хөгжүүлэх, олон улсын интеграцийг бэхжүүлэхэд чухал үр дүн үзүүлж байна.

I БҮЛЭГ. ОНОЛЫН ХЭСЭГ

1.1 Гадаад төлбөр тооцооны тухай ойлголтууд

Гадаад төлбөр тооцоо гэдэг нь олон зуун банк санхүүгийн байгууллагын төлбөр тооцооны үйл ажиллагааг сайжруулах, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн харилцагчийн болон байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой мөнгөн гуйвуулгын сүлжээгээр дамжуулан шилжүүлэх, хүлээн авах, гүйцэтгэх үйл ажиллагаа юм. Гадаад төлбөр тооцооны систем нь нэгдмэл стандарт, протокол, технологиор дамжин ажилладаг бөгөөд эдгээр нь гадаад худалдааны гүйлгээний хурд, аюулгүй байдал, найдвартай байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. (Pritchard, 2018)

Гадаад төлбөр тооцооны онолын судалгааг валют арилжаа, мөнгөн гуйвуулга, олон улсын карт гэсэн гурван үндсэн чиглэлээр нарийвчлан авч үзсэн. Нэгдүгээрт, валют арилжааны онол нь олон улсын төлбөр тооцоонд гадаад валютын ханшийн хөдөлгөөн, валютын зах зээлийн динамик болон гүйлгээний зардлыг хэрхэн зохицуулдаг талаар судлахад чиглэнэ. Хоёрдугаарт, мөнгөн гуйвуулгын онол нь хил дамнасан мөнгөн шилжүүлгийн механизмуудыг тайлбарлаж, гүйлгээний үр ашиг, зардал, хурд, аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар судалсан. Гуравдугаарт, олон улсын картын онол нь төлбөр тооцоонд цахим технологи, картын системийг ашиглах замаар хялбаршуулсан, найдвартай, хүртээмжтэй шийдлүүдийг хэрхэн бий болгож буйг судалсан ба эдгээр гурван үндсэн чиглэлийн онолыг судалснаар гадаад төлбөр тооцооны системийг цогц байдлаар ойлгож онолын суурийг судаллаа.

1.2 Валют арилжаа

Валют арилжаа нь валютын ханшийн өөрчлөлт, арилжааны цэгүүд, брокер компаниудын оролцоотойгоор хийгддэг ба бэлэн болон бэлэн бус гэсэн хэлбэрээр явагддаг. Бэлэн гэдэг ойлголтод валютыг бэлнээр гар дээрээ хүлээн авахыг хэлдэг бол бэлэн бус нь валют харилцах данс эсвэл картын дансанд байх зэрэг орно. (Голомт банк) Олон улсын зах зээлд валютын ханшид нөлөөлөх хүчин зүйлс, жишээ нь эдийн засгийн үзүүлэлт, улс төрийн нөхцөл байдал, гадаад худалдааны баланс зэргийг авч үздэг. (Монголбанк, 2018)

Сүүлийн үед дэлхийн валютын зах зээлд АНУ-ын холбооны нөөцийн банк (Федерал нөөц)-ны хүүгийн бодлого чухал үүрэгтэй байна. 2023 онд Холбооны нөөцийн

банк инфляцын түвшинг 3.7 хувьд хүргэх зорилт тавьсан ба хүүгийн түвшинг 5.5 хувьд барьж байгаа нь АНУ долларын ханшийг дэмжиж байна. Энэ бодлогын үр дүнд АНУ-ын долларын индекс 2023 оны 12-р сараас хойш 7 хувиар өссөн байна. АНУ-ын эдийн засгийн үзүүлэлтээс хамааран валютын зах зээл дэх долларын үнэ цэнэ өөрчлөгдөж байгаа бөгөөд Холбооны нөөцийн бодлого гол үүрэгтэй хэвээр байна. (Financial.times, Longforecast.com)

Евро бүсийн эдийн засаг удааширч байгаа нь еврогийн ам.доллартай харьцах ханшид дарамт үзүүлж байгаатай холбоотой байна. 2024 оны 11-р сарын байдлаар еврогийн ам.доллартай харьцах ханш 1.077 орчим байгаа нь жилийн өмнөхөөс 3.5 хувиар буурсан үзүүлэлт юм. Европын төв банк хүүг бууруулах тухай хэлэлцэж байгаа нь еврогийн ханшид нөлөөлөх магадлалтай бөгөөд хөрөнгө оруулагчид энэхүү чиг хандлагыг харгалзан шинэ стратеги төлөвлөх шаардлагатай болж байна. (Longforecast.com, Forexfactory.com)

Хятад Улс бүс нутгийн валютын тогтвортой байдлыг бэхжүүлэх зорилгоор юанийг олон улсын зах зээлд дэлгэрүүлж байна. Хятадын ардын банк юанийг бусад валюттай харьцуулахад тогтвортой байлгах бодлого баримталж, 2024 онд юань долларын эсрэг ойролцоогоор 6.8 ханштай байгаа нь жилийн өмнөхтэй харьцуулахад 1.2 хувиар буурсан байна. Түүнчлэн BRICS (5 том эдийн засагтай улсын бүлэг бөгөөд үүнд Бразил, Орос, Энэтхэг, Хятад, Өмнөд африк ордог) болон азийн орнуудтай шууд солилцоо хийх нь бүс нутгийн эдийн засгийн интеграцийг дэмжих стратегитай уялдаж байгаа бөгөөд энэ нь дэлхийн зах зээл дээрх ам.долларын хамаарлыг бууруулахад чиглэж байна. (Financial.times; Longforecast.com)

1.3 Гадаад гуйвуулга

SWIFT (Society for Worldwide Interbank Financial)

Зураг 1.1 SWIFT

Дэлхий нийтийн банк хоорондын санхүүгийн харилцаа холбооны нийгэмлэг, товчоор SWIFT («свифт» гэж дууддаг, англи. Society for Worldwide Interbank



Financial Telecommunications) - Олон улсын банк хоорондын төлбөр хийсэн тухай мэдээлэл дамжуулдаг тогтолцоо буюу систем юм. Энэхүү систем нь дэлхий бүх орнуудын санхүүгийн байгууллагууд санхүүгийн гүйлгээ хийсэн тухай мэдээллийг аюулгүй, стандартын дагуу найдвартай илгээх буюу хүлээн авах боломжийг бүрдүүлдэг байна. (Swift.com, bis.org)

Эх сурвалж: Swift.com

SWIFT систем нь дэлхийн банк хоорондын санхүүгийн харилцаанд чухал үүрэгтэй ч зарим улс орнууд олон улсын хориг арга хэмжээний улмаас тус системээс хасагдаж байсан. Тухайлбал, Иран 2012 онд Европын Холбооны хоригийн улмаас SWIFT системээс хасагдсан, 2016 онд цөмийн хэлэлцээрийн дараа хэсэгчлэн сэргээгдсэн ч 2018 онд АНУ-ын шахалтаар дахин хасагдсан. Хойд Солонгос олон улсын хориг арга хэмжээний улмаас SWIFT системд хандах боломжгүй хэвээр байгаа бол ОХУ 2022 онд Украинд түрэмгийлэл үйлдсэний дараа АНУ, Европын Холбоо, Их Британи зэрэг улсуудын санаачилгаар зарим томоохон банкнуудаа SWIFT системээс салгуулсан. Мөн Венесуэл улс 2019 онд АНУ-ын хоригийн улмаас тус системд нэвтрэх боломжгүй болсон байна. SWIFT системээс хасагдах нь тухайн улсын санхүүгийн үйл ажиллагаанд ихээхэн хязгаарлалт үүсгэж, олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтад саад учруулдаг тул Иран, ОХУ, Хятад зэрэг улс орнууд дотоодын төлбөр тооцооны системүүдийг хөгжүүлж, санхүүгийн хараат бус байдлаа нэмэгдүүлэхэд анхаарч байна. (Swift.com)

Санхүүгийн мэдээ дамжуулах SWIFT системийг анх 19 орны 248 банк хамтран 1973 онд анхны ерөнхий захирал Карл Рейтерскиёльдын /Carl Reuterskiöld/ удирдлага дор Бельгид үүсгэн байгуулагдсан ажээ. Төв нь Бельги улсын Брюссель хотын ойролцоо байрладаг байна. SWIFT нь Бельгийн хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан хоршоодын нийгэмлэг бөгөөд гишүүдийн эзэмшилд байдаг байна.

1980-1990 оноос хурдацтай өргөжиж, олон улсын 2000 гаруй банкныг хамарч эхэлсэн. Энэ үед SWIFT нь санхүүгийн шинэ төрлийн гүйлгээний код, формат нэвтрүүлсэн бөгөөд санхүүгийн бүх төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хувьд өөрийн стандартыг бий болгож эхэлсэн юм.

2001 онд интернэтийн хөгжилтэй холбоотойгоор SWIFT нь мэдээллийн улам аюулгүй, хурдан дамжуулах шинэ технологийг нэвтрүүлж, хэрэглэгчдийн тоо болон гүйлгээний цар хүрээ нэмэгдэж эхлэв. Мөн ISO 15022 стандартыг нэвтрүүлж эхэлсэн бөгөөд энэ нь мэдээллийн нэгдсэн формат, кодчиллыг хангах боломжийг бүрдүүлсэн.

2015 оны байдлаар дэлхийн 200 гаруй орны 11 мянга гаруй санхүүгийн байгууллага, түүний дотор 1000 орчим корпорац SWIFT-ийн гишүүнээр элссэн бөгөөд өдөрт дунджаар 30 сая, жилд 5 тэрбум орчим мэдээлэл дамжуулдаг байна. Систем ашиглагчдын албан ёсны хаягийг олон улсын ISO 9362 стандартын дагуу BIC (англи. Business Identifier Code, өмнө нь Bank Identifier Code гэдэг байсан) үндэслэж олгодог байна. Мөн зарим тохиолдолд SWIFT-BIC, SWIFT ID буюу SWIFT code гэж нэрэлдэг байна. Жишээ нь Европд санхүүгийн төлбөр тооцоо/ гүйлгээ хийхэд хүлээн авагчийн албан ёсны нэр бөгөөд банкны IBAN-кодыг мэддэг байхад л хангалттай байдаг байна.

2017 онд Global Payment Innovation (GPI) үйлчилгээг нэвтрүүлсэн нь олон улсын төлбөр тооцоог илүү хурдасгаж, гүйлгээний ил тод байдлыг нэмэгдүүлсэн. Энэ үйлчилгээ нь гүйлгээг бодит цаг хугацаанд хянах, мөн төлбөрийн төлөв байдлыг илүү нарийвчлалтай харах боломжийг олгодог.

2020 онд орчин үеийн технологийг шаардлагыг хангах үүднээс ISO 20022 стандартыг нэвтрүүлж байна. Энэ стандарт нь гүйлгээний мэдээллийн тодорхой байдал, агуулгыг нэмэгдүүлж, SWIFT-ын үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх зорилготой.

2021 онд жижиг банкнууд, санхүүгийн технологийн шинэ тоглогчдод системд нэгдэхэд илүү хялбар байлгах үүднээс зохицуулалтыг сайжруулсан. Энэ нь хөгжиж буй орнууд болон шинэ зах зээлүүдэд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх алхам болсон. Мөн аюулгүй байдлын эрсдэлээс хамгаалахын тулд CSP хөтөлбөрийг шинэчилж, банкнуудын аюулгүй байдлын шаардлагыг улам чангатгасан.


2022 онд ОХУ-Украины дайны улмаас Европын холбоо болон бусад улс орнуудын хориг арга хэмжээний хүрээнд Оросын томоохон банкнуудыг SWIFT

системээс хассан. Энэ нь санхүүгийн системд үзүүлж буй нөлөөллийг харуулсан томоохон үйл явдал болсон.

2023 онд SWIFT-ийн гишүүн байгууллагуудын ихэнх нь ISO 20022 стандартад шилжиж эхэлсэн ба 2025 он гэхэд бүх банк бүрэн шилжихээр зүрж байна. Энэ нь SWIFT-ийн гүйлгээнд илүү нарийвчилсан, нэгдсэн мэдээлэл дамжуулах боломжийг олгож байна. Мөн хиймэл оюун ухаан, блокчейн гэх мэт шинэ технологийн шийдлүүдийг судалж, аюулгүй байдлыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлд ахиц гаргаж байна.

SWIFT системийн олон улсын төлбөр тооцооны үйл явц нь өндөр түвшний стандартчилал, аюулгүй байдлыг ханган ажиллах олон үе шаттай. Эхний ээлжинд төлбөр үүсгэгч өөрийн банканд гүйлгээний хүсэлт гаргаж, SWIFT код, валютын төрөл зэрэг шаардлагатай мэдээллүүдийг өгдөг. Энэхүү мэдээлэл нь SWIFT сүлжээгээр шифрлэгдэн дамжиж, SIPN сүлжээ болон автомат шалгалтын системээр аюулгүй байдлыг баталгаажуулдаг. Хэрэв банк хооронд шууд холбоо байхгүй бол корреспондент банк оролцон зуучлалын үүрэг гүйцэтгэнэ. Корреспондент банкаар дамжуулан төлбөр тооцоо хийх процесс нь олон улсын төлбөрийн шууд холболтгүй банкуудын хооронд зуучлалын үүрэгтэй үйл ажиллагаа юм. Энэ процессын үед корреспондент банк санхүүгийн мэдээллийг хянаж, шаардлагатай тохиолдолд валютыг хөрвүүлэн, хүлээн авагч банк руу мөнгийг шилжүүлдэг. Гүйлгээ хүлээн авагч банканд ирсний дараа тухайн дансанд байршуулж, хүлээн авагчид мэдээлэл хүргэснээр гүйлгээ дуусдаг. SWIFT систем нь гүйлгээний баримт, тайлан гаргаж архивд хадгалах замаар ил тод байдал, хяналтыг нэмэгдүүлдэг бөгөөд энэ бүхэн банк хоорондын харилцааг “Настро” дансаар зохицуулж, гүйлгээний найдвартай байдал, тасралтгүй ажиллагааг хангахад чиглэдэг. Энэ үйл явцыг зураг 1 болон хавсралт 3-д дэлгэрэнгүй харуулсан болно.

Зураг 1.2 SWIFT системээр гүйвуулга хийх процесс



Эх сурвалж: www.swift.com

SWIFT сүлжээ нь олон улсын төлбөр тооцоог өндөр аюулгүй байдал, нарийн зохицуулалттайгаар зохион байгуулдаг. Төлбөрийн процесс эхлэхэд үйлчлүүлэгч нь гүйлгээний мэдээллийг илгээгч байгууллагад өгч, тухайн мэдээлэл SWIFT сүлжээгээр шифрлэгдэн хяналт, шалгалтад ордог. SWIFT нь хоригийн портал болон скрининг хөдөлгүүр ашиглан аюулгүй байдлыг хангаж, зөвшөөрөгдсөн гүйлгээг хүлээн авагч байгууллага руу дамжуулна. Хүлээн авагч банк гүйлгээг хүлээн авч, тухайн үйлчлүүлэгчийн дансанд мөнгийг байршуулж дуусгадаг бөгөөд амжилттай хийгдсэн гүйлгээний мэдээлэл буцаан илгээгч байгууллагад хүрдэг. Энэхүү процесс нь банк хооронд шууд холболтгүй тохиолдолд корреспондент банкнуудыг ашиглах замаар гүйцэтгэгдэж, олон улсын санхүүгийн гүйлгээг найдвартай, тасралтгүй явуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг.


Корреспондент банкны сүлжээ

Корреспондент банк нь тухайн улс оронд банк байхгүй бол өөрийн нэрийн өмнөөс төлбөрийн гүйлгээ хийх зөвшөөрөлтэй банк юм. Тухайлбал, жижиг банкнууд нь өөрийн харилцагчдын төлбөрийг гүйцэтгэхийн тулд томоохон банкны сүлжээг ашигладаг. Энэ нь тухайн банк нь өөрийн харилцагчийн төлбөрийг гүйцэтгэх боломжгүй тохиолдолд корреспондент банкаар дамжуулан гүйлгээг гүйцэтгэх арга юм. Энэ сүлжээг ашиглан оршин суух улсынх нь төлбөр тооцоо хийх боломжийг олгодог бөгөөд гадаад валютын гүйлгээг илүү хялбарчилдаг. Эдгээр бүтэц нь банк хоорондын харилцааг өргөжүүлэх,

төлбөр тооцоог найдвартай, тасралтгүй гүйцэтгэхэд чухал үүрэг гүйцэтгэхэд чухал үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд дэлгэрэнгүй бүтэцийг зураг 2 болон хавсралт 4-өөр харууллаа. (Investopedia.com, 2023)

Корреспондент банкны сүлжээ нь 19-р зууны сүүлчээр дэлхийн худалдааны урсгал нэмэгдэж, олон улсын төлбөр тооцоо хийх хэрэгцээ шаардлага үүссэнтэй холбоотойгоор бий болсон. Эхэн үед томоохон банкнууд хоорондоо уялдаатай ажиллах механизмыг хөгжүүлж, төлбөрийн системийг байгуулахдаа нэгтгэсэн дансны зарчмыг ашигладаг байв. 20-р зууны эхэн үед (1940-1970) худалдаа, эдийн засгийн глобалчлал нэмэгдэж, санхүүгийн системүүдийн харилцан хамаарал гүнзгийрэхийн хэрээр корреспондент банкны үүрэг улам чухал болж, олон улсын валютын гүйлгээний найдвартай арга хэрэгсэл болж хөгжсөн. 1970-аад онд Америк, Европын томоохон банкнууд корреспондент сүлжээ үүсгэн, гадаад валютын зах зээлд гүйлгээ хийх болон төлбөрийн харилцааг шинэчилж, сайжруулсан. Харин 1990-2000-аад оны үед корреспондент банкны сүлжээ гадаад төлбөр тооцоо, валютын зах зээлд голлох үүрэгтэй болж, тусгай системүүд болон программ хангамжуудыг хөгжүүлснээр бүх банкнууд энэхүү сүлжээг ашиглан төлбөр тооцоо гүйцэтгэх боломжтой болсон.

Зураг 1.3 Корреспондент банкны бүтэц



Эх сурвалж: Судлаачийн нэгтгэлээр

Корреспондент банкны бүтэц нь төлбөр тооцоо, гүйлгээний зохицуулалтыг оновчтой болгохын тулд уламжлалт, үүрэгжсэн, дамжуулан төлөх буюу дамжин өнгөрөх гэсэн гурван үндсэн ангилалд хуваагддаг. Уламжлалт корреспондент банк нь харилцагч банк өөрийн харилцагчдын гадаад гүйлгээг гүйцэтгэх боломжгүй үед тусгай зөвшөөрөл бүхий корреспондент банкаар дамжуулан төлбөрийг зохицуулдаг. Харин үүрэгжсэн корреспондент банк нь олон тооны жижиг банкнуудын гүйлгээг төвлөрүүлэн зохицуулж, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг өргөтгөдөг. Дамжуулан төлөх буюу дамжин өнгөрөх корреспондент банк нь шууд холболтгүй банкуудын хооронд зуучлалын үүрэг гүйцэтгэж, олон улсын төлбөр тооцоог эцсийн хүлээн авагчид хүргэдэг. Эдгээр бүтэц нь банк хоорондын харилцааг найдвартай, хурдтай, үр ашигтай зохицуулахад чиглэдэг.

Зураг 1.4 Western union

Дэлхийн мөнгөн шилжүүлгийн салбарт тэргүүлэгч бөгөөд үндсэн үйл ажиллагаа нь олон



улсын мөнгөн гуйвуулга, цахим мөнгө илгээх төлбөр төлөлтийн үйлчилгээнд чиглэгддэг. Энэхүү байгууллага нь 500,000 гаруй төлөөлөгчийн газар болон 200 гаруй улс оронд өргөн сүлжээгээр дамжуулан мөнгө шилжүүлэх, хүлээн авах үйлчилгээг санал болгодог. (Westernunion.com)

Эх сурвалж: Westernunion.com

Western Union-оор дамжуулан төлбөр тооцоо хийх 4 шат дарааллыг доорх хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 1.1 Western Union-оор дамжуулан төлбөр тооцоо хийх процесс

1. Мөнгө илгээх хүсэлт	Илгээгч нь Western Union-ийн салбар, вэбсайт эсвэл аппликейшнээр дамжуулан мөнгө шилжүүлэх хүсэлт гаргана. Илгээгч нь хүлээн авагчийн мэдээлэл (нэр, оршин суугаа улс орон), мөн шилжүүлэх мөнгөн дүнг оруулж, үйлчилгээний хураамжийг төлдөг.
2. Мэдээллийн баталгаажуулалт	Western Union илгээгчийн мэдээллийг баталгаажуулж, залилан болон хууль бус үйл ажиллагаанаас сэргийлэх үүднээс КҮС (Харилцагчаа таних) журам болон бусад аюулгүй байдлын арга хэмжээг авдаг.
3. Гүйлгээ дамжуулалт	Баталгаажсаны дараа Western Union гүйлгээгээ боловсруулж, хүлээн авагчийн оронд байрлах салбар руу мөнгөний дүнг шилжүүлдэг. Энэ процесс нь аюулгүй байдлын системүүд болон SWIFT, Western Union-ийн өөрийн дотоод сүлжээ гэх мэт санхүүгийн дамжуулалтын арга хэрэгслүүдээр дамжин явагддаг.
4. Хүлээн авах	Хүлээн авагч нь Western Union-ийн сонгосон салбар эсвэл агент руу очиж, шилжүүлгийн дугаар (MTCN), өөрийн

иргэний үнэмлэх эсвэл бусад таних бичиг баримтаар мөнгөө хүлээн авдаг. Зарим оронд мөнгийг банкны данс эсвэл мобайл хэтэвч рүү шууд шилжүүлэх боломжтой.

Эх сурвалж: *Western Union*

Анх 1851 онд үүсгэн байгуулагдсан Western Union компани нь эхэндээ АНУ-ын дэд бүтцэд тулгуурлан цахилгаан мэдээ дамжуулах үйлчилгээ үзүүлдэг байв. 1861 онд анхны хөндлөнгийн цахилгаан мэдээний шугамыг ашиглалтад оруулж, ерөнхийлөгч Абрахам Линкольнд анхны цахилгаан мэдээг илгээсэн нь түүхэн амжилт болж, компани харилцаа холбооны технологийн анхдагчийн нэг болжээ. 1871 онд цахилгаан мөнгөн шилжүүлгийн үйлчилгээгээ нэвтрүүлснээр алслагдсан бүс нутагт мөнгө шилжүүлэх зайлшгүй хэрэгсэл болсон бөгөөд Western Union харилцаа холбооны салбарт тэргүүлэх байр суурь эзэлж эхэлсэн юм. XX зууны дунд үеэс утасны технологи хөгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус компани олон улсын мөнгөн шилжүүлгийн системд төвлөрөх болж, өнөө үед вэбсайт болон мобайл аппликейшн ашиглан мөнгө шилжүүлэх, банкны данс руу шууд шилжүүлэх, мобайл хэтэвч ашиглах зэрэг хурдан, хялбар шийдлүүдийг дэлхий даяарх хэрэглэгчдэд санал болгож байна.

Зураг 1.5 Moneygram



MoneyGram

MoneyGram бол дэлхий даяарх мөнгөн шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгч компани бөгөөд хувь хүмүүс, гэр бүлүүдэд олон улсын болон дотоодын мөнгөн шилжүүлгийг хурдан, аюулгүй хийх боломжийг олгодог. Үйлчлүүлэгчид

MoneyGram-ийн сүлжээтэй 200 гаруй улс орон, бүс нутгийн 350,000 гаруй төлөөлөгчийн газраар дамжуулан биечлэн эсвэл онлайнгаар мөнгө илгээх, хүлээн авах боломжтой айдаг. Компани нь мөн шууд банкны данс руу шилжүүлэх, мобайл хэтэвч болон мөнгө бэлнээр авах үйлчилгээг санал болгодог. (Moneygram.com)

Эх сурвалж: *Moneygram.com*

MoneyGram-аар дамжуулан төлбөр тооцоо хийх 5 үе шатыг доорх хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 1.2 MoneyGram-аар дамжуулан төлбөр тооцоо хийх процесс

1. Шилжүүлэгчийн хүсэлт	Мөнгө илгээгч нь MoneyGram-ийн төлөөлөгчийн газар, вэбсайт, мобайл аппликейшн эсвэл банкны салбараар дамжуулан гүйлгээний хүсэлтээ гаргана. Мөнгөө илгээхдээ хүлээн авагчийн мэдээлэл, гүйлгээний дүн, валют зэрэг мэдээллийг оруулдаг.
2. Шилжүүлэгчийн баталгаажуулалт	MoneyGram нь мөнгө илгээж буй этгээдийн мэдээллийг шалгаж, гүйлгээг баталгаажуулах арга хэмжээ авдаг. Энэ нь мөнгө угаах болон залилангийн эсрэг хамгаалалтын системүүдийг багтаадаг.
3. Гүйлгээг дамжуулах	Гүйлгээг баталгаажуулсны дараа MoneyGram өөрийн системийг ашиглан мөнгийг хүлээн авагчийн оронд хүргэх үйл ажиллагааг эхлүүлдэг. Энэ нь SWIFT, банкны сүлжээ болон мобайл үйлчилгээ үзүүлэгчдийн хамтарсан шийдлүүдээр дамжин хийгддэг.
4. Хүлээн авагчийн мэдээлэл баталгаажуулалт	Хүлээн авагч нь өөрийн иргэний үнэмлэх болон бусад баримт бичгийг ашиглан мөнгөө хүлээн авдаг. Зарим оронд банкны данс руу шууд шилжүүлэх эсвэл мобайл хэтэвч рүү мөнгө оруулах боломжтой.
5. Гүйлгээний аюулгүй байдлын хяналт	MoneyGram нь дэлхийн хэмжээнд санхүүгийн залилан болон хууль бус үйл ажиллагааг илрүүлэх аюулгүй байдлын дэвшилтэт системүүдийг ашигладаг. Ингэснээр MoneyGram-ийн сүлжээнд гүйцэтгэгдэж буй гүйлгээний эрсдэл буурч, хэрэглэгчдэд аюулгүй байдлыг ханган ажилладаг.

Эх сурвалж: Moneygram.com

Аккредитив

Аккредитив буюу итгэмжлэл нь худалдан авагчийн өмнөөс банкнаас гаргадаг санхүүгийн баримт бичиг бөгөөд борлуулагч шаардлагыг биелүүлсэн тохиолдолд төлбөрийг хүлээн авах баталгааг өгдөг. Тухайлбал, гуравдагч талд төлбөрийг зөвшөөрөх, эсвэл өөрийн нэр дээр төлбөр хийгдсэнийг баталгаажуулах замаар гуравдагч талд төлбөр гүйцэтгэх юм. Аккредитивыг үндсэндээ баталгаатай (Confirmed LC) болон баталгаагүй (Unconfirmed LC) гэсэн хоёр төрөлд хувааж, олон улсын худалдаанд санхүүжилтийн механизм болон нийлүүлэгчийн сонирхлыг хамгаалах үүрэг гүйцэтгэдэг. Түүнчлэн импортын аккредитив нь бараа бүтээгдэхүүний төлбөрийг худалдаачид бүрэн баримтын дагуу төлөхийг, харин экспортын аккредитив нь орон нутгийн банкнуудад орлого хүлээн авахыг баталгаажуулдаг.

Аккредитив нь олон зуун жилийн түүхтэй бөгөөд анх худалдаачид урт зайны гүйлгээг найдвартай хийхийн тулд ашиглаж байсан байна. 19-20-р зууны үед олон улсын худалдаа өргөжихийн хэрээр энэ хэрэгслийн орчин үеийн хэлбэр бүрэлдэж, стандартад нийцсэн зааварчилгаанууд бий болжээ. Олон Улсын Худалдааны Танхим (ICC) 1933 онд Баримт бичгийн итгэмжлэлийн нийтлэг журам (UCP)-ийг боловсруулсан бөгөөд энэ нь өнөөгийн аккредитивын гол дүрэм болсон юм. UCP нь олон удаа шинэчлэгдсэн ба хамгийн сүүлийн шинэчлэл болох UCP 600 нь 2007 онд хэрэгжиж эхэлсэн. (Icswbo.org)

Аккредитиваар дамжин төлбөр тооцоо хийх үе шатыг доорх зурагт харууллаа.

Зураг 1.6 Аккредитивийн үе



Эх сурвалж: (Өнөмөнх.Э, 2021)

Аккредитивын үе шат нь олон улсын худалдаанд худалдан авагч, худалдагч хоёрын хооронд итгэлцлийг хангах найдвартай арга бөгөөд банкны зуучлалаар хэрэгждэг. Энэ үйл явцад худалдан авагч аккредитив нээх хүсэлт гаргаж, түүний банк шаардлагыг хангасан аккредитивыг худалдагчийн банканд илгээдэг. Худалдагч барааг илгээж,

шаардлагатай баримт бичгийг бүрдүүлсний дараа эдгээрийг банканд хүргүүлж шалгуулдаг. Баримт бичгүүд аккредитивын нөхцөлд нийцсэн тохиолдолд худалдан авагчийн банк төлбөрийг баталгаажуулж, шилжүүлнэ. Эцэст нь худалдагч төлбөрөө хүлээн авч, худалдан авагч бараагаа хүлээн авснаар процесс дуусна. Энэ нь найдвартай, эрсдэл багатай, олон улсын стандарттай нийцсэн шийдэл юм.

Инкасс

Инкасс гэдэг нь санхүүгийн баримт бичиг, төлбөрийн баримт бичиг, ачилтын баримт бичиг зэрэг худалдааны баримт бичгийг худалдаалагч талаас худалдан авагч талд банканд дамжуулан хүргүүлэх замаар төлбөр хийх процесс юм. Энэхүү үйл ажиллагаа нь банкны баталгаа байхгүйгээр худалдагч болон худалдан авагчийн хооронд найдвартай төлбөр тооцоо хийх боломжийг бүрдүүлдэг тул бага зэрэг эрсдэлтэй ч зардал багатай байдаг ба найдвартай төлбөр тооцооны нэг хэлбэр болдог тул жижиг дунд хэмжээний гадаад худалдаанд өргөн хэрэглэдэг.

Инкасс нь баримт бичгийн инкасс болон шууд инкасс гэсэн хоёр үндсэн төрөлд хуваагддаг. Баримт бичгийн инкасс нь гадаад худалдааны хэлцлийн хүрээнд худалдааны баримт бичгүүдийг худалдан авагчид шилжүүлэхтэй холбоотой бол шууд инкасс нь бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөрийг данснаас шууд суутгах үйл явцыг хамардаг. Инкассын эдгээр төрлийн онцлог, үйл ажиллагааны зарчмыг доорх хүснэгтэд дэлгэрэнгүй тайлбарлав.

Хүснэгт 1.3 Инкассын төрөл

Баримт бичгийн инкасс	Барааг эзэмших эрхийн баримтуудыг өөрийн банкиндаа өгснөөр экспортлогч бараандаа хяналт тавьдаг механизм ба баримт бичгийг хүлээн авагч нь барааны төлбөрийг төлсний дараа авах эрхтэй.
Шууд буюу цэвэр инкасс	Худалдагчийн зүгээс борлуулсан бүтээгдэхүүнтэй холбоотой баримт бичгүүдийг худалдан авагчид явуулсны дараа өөрийн үйлчлэгч банкинд хандаж худалдан авагчаас төлбөр төлүүлэх ажлыг даатгадаг. Төлбөрийн вексель, чек зэрэг санхүүгийн баримтыг банкинд дамжуулан төлбөрийг нэхэмжилнэ.

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэлээр

Инкасс нь олон улсын худалдааны хөгжлийн эхэн үеэс үүсэлтэй бөгөөд 19-р зуунд Европт худалдааны эрсдэлийг бууруулж, илүү хялбар төлбөрийн системийг бий болгох шаардлагатай болсон үед анх ашиглагдаж эхэлжээ. Тухайн үед худалдаачид бие биедээ шууд итгэх боломжгүй учир худалдааны баримт бичгийг банканд хүлээлгэн өгч, худалдан авагчид дамжуулан төлбөрийг баталгаажуулдаг арга түгээмэл байв. Улмаар 20-р зууны дунд үед Олон Улсын Худалдааны Танхим (ICC) инкассыг олон улсын түвшинд нэг стандартад нийцүүлэх зорилгоор “Uniform Rules for Collections” (URC 522) дүрмийг боловсруулсан нь инкассын гүйлгээний банкны үүрэг, баримт бичгийн шаардлага, төлбөрийн нөхцөлийг нарийвчлан тодорхойлж, гүйлгээг илүү аюулгүй, итгэлтэй болгосон юм. Энэ нь олон улсын худалдааны гүйлгээнд инкассыг өргөнөөр ашиглах боломжийг бүрдүүлж, худалдааны төлбөр тооцоог хөнгөвчлөх, дэмжихэд чухал үүрэгтэй арга болоход нөлөөлжээ.

Инкассын процессийн үе шатыг доорх зурагт харуулав.

Зураг 1.7 Инкассын үе шат



Эх сурвалж: (Өнөмөнх.Э, 2021)

Инкассын процесс нь экспортлогч болон импортлогчийн хооронд худалдааны гэрээ байгуулах үеэс эхэлдэг. Экспортлогч барааг ачуулсны дараа холбогдох баримт бичгүүдийг өөрийн банк руу илгээнэ. Экспортлогчийн банк эдгээр баримтуудыг импортлогчийн банк руу дамжуулж, импортлогчид мэдэгдэнэ. Импортлогч барааны төлбөрийг гүйцэтгэсний дараа баримтыг хүлээн авч, бараагаа авах боломжтой болдог. Эцэст нь, төлбөр импортлогчийн банкнаас экспортлогчийн банк руу шилжиж, инкассын үйл явц дуусдаг. Энэ процесс нь худалдааны гүйлгээнд оролцогч талуудад аюулгүй, итгэлтэй орчныг бүрдүүлдэг.

1.3 Олон улсын төлбөрийн карт

Олон улсын төлбөрийн картууд нь гадаадын худалдаа, аялал жуулчлал, онлайн төлбөр тооцоо хийхэд өргөн хэрэглэгддэг цахим мөнгөний хэрэгслүүд юм. Эдгээр картууд нь үндсэндээ Visa, Mastercard, American Express, Discover, Union pay зэрэг дэлхийд алдартай санхүүгийн байгууллагуудаар дамжин гардаг. Эдгээр картууд нь олон улсын худалдааны төлбөр тооцоог хялбар, аюулгүй, хурдан хийх боломжийг олгодог бөгөөд хэд хэдэн төрлөөр ангилагддаг. (Visa.com, mastercard.com, ifc.org)

1. Зээлийн карт (Credit Card): Карт эзэмшигчид банкнаас тодорхой хэмжээний зээлийн эрх авах бөгөөд энэ эрхээр худалдан авалт болон гүйлгээ хийх боломжтой. Өртгийг хугацаанд нь төлөх үүрэгтэй бөгөөд энэ төрлийн карт нь ашиглалтын үр дүнд хүү тооцдог.
2. Дебит карт (Debit Card): Карт эзэмшигч өөрийн данснаас шууд мөнгө зарцуулах боломжтой байдаг. Энэ төрлийн карт нь төлбөр хийх үед эзэмшигчийн дансанд байх үлдэгдэл дотор гүйлгээ хийгддэг тул зээлийн эрх олгохгүй.
3. Урьдчилсан төлбөрт карт (Prepaid Card): Картанд урьдчилан мөнгө цэнэглэж, энэ доторх хэмжээгээр зарцуулалт хийдэг. Энэ нь зээлийн болон дебит картын хослол мэт бөгөөд ихэвчлэн аялал, гадаадад төлбөр тооцоонд өргөн хэрэглэгддэг.
4. Бизнесийн картууд (Business or Corporate Cards): Байгууллагуудад зориулсан картууд бөгөөд ажилчид бизнес аялал, гүйлгээгээ хийхэд ашигладаг.

Олон улсын төлбөрийн картууд нь EMV чип, PIN код, OTP баталгаажуулалт зэрэг аюулгүй байдлын арга хэрэгслүүдийг ашиглан карт эзэмшигчдийн мэдээллийг хамгаалдаг. Олон улсын төлбөрийн картын сүлжээ нь хэрэглэгчийн төлбөрийг зохицуулах төв банк, карт эзэмшигчийн банк, худалдагчийн банкны хооронд дамжуулах үүрэгтэй байдаг. (Ifc.org)

Олон улсад кредит болон дебит картын ашиглалт бүс нутгуудаас хамааран харилцан адилгүй байна. Visa нь 2023 онд дэлхийн нийт картын гүйлгээний 38.78%-ийг эзэлж, тэргүүлэгч байр сууриа хадгалж байна. UnionPay нь Хятадын дотоодын зах зээлд өргөн хэрэглэгддэг бөгөөд олон улсын зах зээлд нөлөөгөө өргөжүүлж байна. Mastercard нь дэлхийн хоёр дахь том картын сүлжээ бөгөөд 2023 оны байдлаар 2.94 тэрбум карт ашиглагдсан. American Express нь дэлхийн бус, АНУ-ын зах зээлд голчлон үйл ажиллагаагаа төвлөрүүлж, зээлийн картын гүйлгээний 10.17%-ийг боловсруулдаг.

Discover нь АНУ-ын зах зээлд чухал байр суурь эзэлдэг бөгөөд 2023 онд 220 тэрбум долларын гүйлгээ хийжээ. Орчин үед цахим хэтэвчнүүд картын системтэй шууд холбогдон, токенжуулалт ашиглан илүү аюулгүй, хялбар гүйлгээ хийх боломжийг бүрдүүлж байна.



Картын төлбөрийн системийн нийцтэй байдал улс бүрийн онцлогоос хамаарч өөр өөр байна. Жишээлбэл, Хятадад Unionpay картын сүлжээ хамгийн өргөн тархсан бөгөөд тус улсын POS төхөөрөмжүүд нь ихэнх тохиолдолд зөвхөн UnionPay картуудыг хүлээн авдаг. Үүний улмаас Хятадад зорчсон олон улсын хэрэглэгчид бусад картын сүлжээний картуудыг ашиглах боломжгүй болох тохиолдол гарч болзошгүй. Харин Европ болон АНУ-д Visa, Mastercard зэрэг картын сүлжээнүүд илүү түгээмэл ашиглагддаг бөгөөд Unionpay нь эдгээр бүс нутагт харьцангуй хязгаарлагдмал хүлээн авалттай байдаг. Иймээс, Европ болон АНУ руу зорчиж буй хэрэглэгчид Visa эсвэл Mastercard картуудыг амжилттай ашиглаж чаддаг ба Unionpay картын ашиглалт нь зарим тохиолдолд хязгаарлагдмал байх нь хэрэглэгчдэд асуудал үүсгэж болзошгүй байна. Энэ нь олон улсын төлбөрийн системүүдийн хоорондын нийцтэй байдлыг сайжруулах шаардлагыг нэмэгдүүлж байна.


Цахим хэтэвч

Цахим хэтэвч нь картын системийн нэг хэсэг бөгөөд хэрэглэгчдэд хурдан, аюулгүй төлбөр тооцоо хийх боломжийг олгодог цахим хэрэгсэл юм. Мобайл хэтэвч (жишээ нь, Apple Pay, Google Pay, Samsung Pay) нь гар утас болон бусад төхөөрөмжийг ашиглан төлбөр хийх боломжийг олгодог бөгөөд энэ нь картын системд холбогдож гүйлгээ хийхэд ашиглагддаг. Тэгвэл онлайн хэтэвч (жишээ нь, PayPal, Alipay, WeChat Pay) нь интернет дээр төлбөр тооцоо хийх боломжийг олгодог бөгөөд энэ нь ихэвчлэн цахим худалдааны платформ дээр хэрэглэгддэг. Эдгээр хэтэвчүүд нь токенжуулалт ашиглан аюулгүй байдлыг хангадаг бөгөөд хэрэглэгчид картын мэдээллээ илүү хамгаалсан байдлаар хадгалж, гүйлгээ хийх боломжийг олгодог. Ингэснээр эдгээр цахим хэтэвчүүд нь картын төлбөрийн системтэй интеграцлагдсан бөгөөд хэрэглэгчдэд бэлэн мөнгө, карт авч явах шаардлагагүйгээр төлбөр хийх боломжийг олгож байна. Доорх хүснэгтэд цахим хэтэвчний төрлүүдийн талаар үйл ажиллагааг дэлгэрэнгүй харууллаа.

Хүснэгт 1.4 Цахим хэтэвчний төрлүүд

Флатформуудын (нэр, лого)	Үйл ажиллагааны зарчим	Аюулгүйн байдал	Картын холбоос
<p>Зураг 1.8 Apple pay</p>  <p><i>Эх сурвалж: applepay</i></p>	<p>NFC (Near Field Communication) технологид тулгуурлан картын мэдээллийг хадгалдаг ба POS терминалуудтай холбогдож төлбөрийн гүйлгээ хийдэг.</p>	<p>Хурууны хээ, нүүр танилт болон тухайн төхөөрөмжид хадгалагдсан токенжуулалт бүхий картын мэдээлэл дээр суурилдаг тул аюулгүй.</p>	<p>Хэрэглэгчийн кредит эсвэл дебит карттай холбогдсон байдаг бөгөөд картын сүлжээ болох (Visa, Mastercard гэх мэт)-ээр дамжин гүйлгээ хийдэг.</p>
<p>Зураг 1.9 Googlepay</p>  <p><i>Эх сурвалж: Googlepay</i></p>	<p>NFC технологи ашиглан төлбөр төлөх боломжийг олгодог бөгөөд онлайн худалдаа, аппликэйшн дээр ч ашиглагддаг.</p>	<p>Токенжуулалтын технологи ашиглан картын мэдээллийг хамгаалдаг, мөн төлбөрийн үйл явцын үе шат бүрт нэмэлт баталгаажуулалт байдаг.</p>	<p>Хэрэглэгчийн картын мэдээллийг хадгалж, картын сүлжээ ашиглан гүйлгээг гүйцэтгэдэг.</p>
<p>Зураг 1.10 Samsungpay</p>  <p><i>Эх сурвалж: Samsungpay</i></p>	<p>NFC болон MST (Magnetic Secure Transmission) технологийг ашиглан физик карт уншигч дээрх соронзон туузанд</p>	<p>Токенжуулалт, хурууны хээ, нүдний торлог таних зэрэг баталгаажуула ашигладаг.</p>	<p>Хэрэгдэгчийн кредит эсвэл дебит карттай холбогдож гүйлгээг хийнэ.</p>

	карт уншуулж мэт гүйлгээ хийдэг.		
<p>Зураг 1.11 Paypal</p>  <p><i>Эх сурвалж: Paypal</i></p>	Онлайн худалдаа, мөнгөн гуйвуулга хийхэд зориулсан платформ. Картын холболттой байх боломжтойгоос гадна хэрэглэгчийн PayPal данснаас шууд шилжүүлэг хийх боломжтой.	Баталгаажуулалт зэрэг аюулгүй байдлын нэмэлт давхаргатай.	Карт эсвэл банкны данстай холбогдож, олон улсын гүйлгээнд ашиглагддаг.
<p>Зураг 1.12 Wechatpay</p>  <p><i>Эх сурвалж: Wechatpay</i></p>	Апликэйшин дээр байрласан энэхүү платформ нь QR код ашиглан худалдаа, үйлчилгээний төлбөр хийхэд ашиглагддаг. Хятадын дотоодын зах зээлд өргөн тархсан төлбөрийн хэрэгсэл.	QR кодын баталгаажуулалт, хэрэглэгчийн аюулгүй байдлын тохируулгатай.	Ихэвчлэн Хятадын банкны карт эсвэл данстай холбогдож юм уу Unionpay картын сүлжээг ашиглан төлбөр тооцоо хийдэг.
<p>Зураг 1.13 Alipay</p>	QR код болон токенжуулалт ашиглан худалдаа, төлбөрийн үйлчилгээг гүйцэтгэдэг.	SMS баталгаажуулалт, QR код, цахим гарын үсэг зэрэг аюулгүй	Банкны дансанд шууд холбогдож, олон улсын гүйлгээнд картын сүлжээ (Visa, Mastercard, Union

 <p>Эх сурвалж: Alipay</p>	Ихэнх тохиолдолд Хятадын дотоодын төлбөр тооцоонд ашиглагддаг.	байдлын нэмэлт давхаргуудтай.	рау) зэрэгт ашиглан төлбөр тооцоо хийдэг.
---	--	-------------------------------	---

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэлээр

Бүлгийн дүгнэлт

Гадаад төлбөр тооцооны онол, арга зүйн судалгаа нь олон улсын санхүүгийн тогтолцооны чухал хэсгийг тодорхойлж, гүйлгээний хурд, найдвартай байдал, аюулгүй байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн байдаг. Олон улсын валют арилжаа, гуйвуулга, SWIFT болон Western Union зэрэг төлбөрийн хэрэгслүүд нь дэлхийн эдийн засгийн интеграцид чухал үүрэг гүйцэтгэж байна. SWIFT системийн хөгжлийн явцад нэвтрүүлсэн шинэчлэлүүд, тухайлбал ISO 20022 стандарт болон GPI үйлчилгээ нь гүйлгээний явцыг илүү үр ашигтай, ил тод болгож, дэлхийн санхүүгийн системийн найдвартай байдлыг хангахад тусалж байна.

Мөн валют арилжааны зах зээл дэх хүүгийн бодлого, эдийн засгийн үзүүлэлтүүд, улс төрийн нөхцөл байдлуудын нөлөөллийг судалснаар валютын ханшийн өөрчлөлт, худалдааны балансын удирдлагад үр дүнтэй аргачлалуудыг боловсруулах боломжтой юм. Аккретив болон инкасс зэрэг төлбөрийн хэрэгслүүд нь олон улсын худалдаанд итгэлцлийг нэмэгдүүлж, санхүүгийн эрсдэлийг бууруулахад чухал ач холбогдолтой. Олон улсын төлбөрийн картууд болон цахим хэтэвчүүдийн өргөн хэрэглээ нь гадаад худалдааг хялбаршуулж, цахим төлбөр тооцооны хөгжлийг хурдасгаж байна.

Энэхүү бүлэгт гадаад төлбөр тооцооны хэрэгслүүдийн онол, арга зүй, үүсэл хөгжил, тэдгээрийн үр нөлөөний талаар авч үзэж, олон улсын санхүүгийн системд үзүүлж буй нөлөөллийг тодорхойлсон болно. Цаашид Монголын нөхцөлд тохируулан ашиглаж болохуйц олон улс дахь төлбөрийн хэрэгслүүдийг судалж, арилжааны банкнуудын өнөөгийн байдлын судалгаан дээр үндэслэн дөрөвдүгээр бүлэгт үр дүнг боловсруулах болно.

II БҮЛЭГ. САЛБАРЫН СУДАЛГАА

2.1 Арилжааны банкуудын өнөөгийн байдлын судалгаа


1991 оны 5 дугаар сарын 20-нд Монгол Улсын хоёр шатлалтай банкны тогтолцоог Монголбанкны удирдлага дор бий болгосон. Монголбанк нь банк хоорондын төлбөр тооцоог зохицуулах үүрэг хүлээсэн бөгөөд энэ үүргийг 1996 оны 9 дүгээр сарын 3-нд батлагдсан Төв банкны тухай хуулиар дахин баталгаажуулсан юм. 1997 онд Монголын банкнууд олон улсын SWIFT сүлжээнд холбогдож, дэлхийн банкны сүлжээгээр аюулгүйгээр гадаад валютын шилжүүлгийг хийх боломжтой болсон нь олон улсын гүйлгээний хурд, аюулгүй байдал, найдвартай байдлыг хангах чухал алхам болсон.

Арилжааны банкнууд SWIFT системийн шинэчлэлтүүдийг нэвтрүүлж, орчин үеийн технологийг ашиглан олон улсын стандартад нийцүүлэн ажиллах болсон нь банкны үйл ажиллагааны ил тод байдал, аюулгүй байдлыг сайжруулж, хэрэглэгчдийн итгэлийг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн. Тухайлбал, SWIFT GPI (Global Payments Innovation) системийг нэвтрүүлснээр гадаад төлбөр тооцооны хурд, ил тод байдал, бодит цагийн хяналт зэрэг давуу талуудыг олгож байна. Арилжааны банкнууд 2022 онд SWIFT сүлжээгээр 1.2 сая гаруй гүйлгээ гүйцэтгэсэн бол 2023 онд энэ тоо 1.5 саяд хүрсэн нь гадаад төлбөр тооцооны эрэлт нэмэгдэж байгааг харуулж байна.

Монгол Улс 2020 онд саарал жагсаалтад багтаж, олон улсын санхүүгийн систем дэх банкны комплайнсын эрсдэл нэмэгдэж, гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаанд хүндрэл үүсэж байсан. 2022 онд саарал жагсаалтаас гарснаар Монголын арилжааны банкуудын корреспондент харилцаа аажмаар сэргэж, 2023 онд АНУ-ын New York Mellon банканд ам.долларын данс нээх боломжтой болсон нь гадаад төлбөр тооцооны найдвартай байдлыг бэхжүүлэх чухал алхам болсон юм. Энэ нь Монголын гадаад худалдааны гол түнш болох Хятад, ОХУ-тай хийж буй гүйлгээнүүдээс хамааралтайгаар стратегийн ач холбогдолтой шийдэл болж байна.

Монгол Улсын гадаад төлбөр тооцооны шимтгэл, төлбөрийн саатал нь арилжааны банкнуудын үйл ажиллагаанд сорилт хэвээр байгаа бөгөөд нэг гүйлгээнд дунджаар 1-3 хувийн шимтгэл ногдож байна. Олон улсын хориг арга хэмжээ болон ОХУ-аас хийж буй 2 тэрбум ам.долларын стратегийн чухал импортын гүйлгээнд үзүүлэх төлбөр тооцооны эрсдэл өндөр байна. Иймд Монгол Улс дотоодын банкнуудын технологийн шинэчлэлийг хурдасгах, SWIFT сүлжээний шинэ боломжуудыг үр дүнтэй ашиглах, олон улсын төлбөрийн системүүдтэй илүү нягт уялдаа холбоотой ажиллах шаардлагатай байна.

Зураг 2.1 Арилжааны банкнуудын гадаад актив, пассив



Эх сурвалж: 1212.тп,2023

2019-2024 оны хооронд Монгол Улсын гадаад актив, пассивын динамик өөрчлөлтийг дүгнэхэд, гадаад пассивын хэмжээ тасралтгүй өсөж, 2024 оны 1-р улиралд хамгийн өндөр түвшинд хүрсэн нь гадаад өр, зээлийн хэмжээг огцом нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. Энэ нь улсын эдийн засгийн ачааллыг нэмэгдүүлэхээс гадна өрийн тогтвортой байдалд тодорхой хэмжээний дарамт үүсгэж буйг харуулж байна. Харин гадаад активын хэмжээ 2022 онд өсөлт үзүүлсэн боловч 2023 оноос буурч, 2024 оны 1-р улиралд тогтворжсон нь валютын нөөц болон хөрөнгө оруулалтын урсгалын тогтворгүй байдлыг илтгэж байна. Гадаад актив, пассивын хоорондын зөрүү нэмэгдэж буй нь Монгол Улсын гадаад санхүүгийн тэнцвэр алдагдаж байгааг харуулж байгаа бөгөөд энэ нь санхүүгийн тогтвортой байдлыг урт хугацаанд хангах бодлого хэрэгжүүлэх шаардлагатайг илэрхийлж байна. Иймд, гадаад активыг нэмэгдүүлэх, экспортын орлогыг өсгөх, валютын урсгалыг тэнцвэржүүлэх, зээл, өрийн хэт хамаарлыг бууруулах зэрэг зохицуулалтын бодлого хэрэгжүүлэх нь чухал байна.


Зураг 2.2 Монгол Улсын нийт импорт, экспортын хэмжээ (хувиар)



Эх сурвалж: 1212.mn, 2023

Энэхүү зурагт 2019-2023 оны хооронд Монгол Улсын экспорт, импортын чиг хандлагыг харуулж, худалдааны хэмжээ тогтвортой өссөн болохыг илтгэж байна. 2023 онд экспорт 55.4%-ийг эзэлж, импорт 44.6%-ийг эзэлснээр экспорт илүү давамгайлж байна. Энэ нь Монгол Улсын экспортын чадавх бэхжиж байгааг харуулж байгаа бөгөөд нөгөө талаас дотоодын хэрэгцээг хангахын тулд импортод илүү тулгуурлаж байгааг илэрхийлж байгаа бөгөөд худалдааны өрсөлдөх чадвар болон эдийн засгийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх тэнцвэртэй хандлагыг харуулж байна.

Зураг 2.3 Монгол Улсын экспортын хэмжээ (улсаар)




Эх сурвалж: 1212.mn, 2023

2019-2023 оны хооронд Монгол Улсын экспортын гол түнш орон БНХАУ байсаар байна. Тус улсад хийсэн экспортын хэмжээ 2023 онд 13.9 тэрбум ам.долларт хүрч, нийт экспортын дийлэнх хувийг бүрдүүлж байна. Энэ нь Монгол Улсын эдийн засаг БНХАУ-ын эрэлт хэрэгцээ, худалдааны харилцаанаас ихээхэн хамааралтай болохыг харуулж байна. Үүнтэй зэрэгцэн Европын Холбоо Монголын экспортын хоёр дахь гол зах зээл болж, 2023 онд 137.9 сая ам.долларт хүрчээ. Энэ нь Монголын уул уурхайн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүд Европын зах зээлд тогтмол байр суурьтай байгааг илтгэнэ.

ОХУ-ын экспортын эзлэх хувь харьцангуй бага байгаа бөгөөд 2023 онд 112.7 сая ам.долларт хүрсэн байна. Энэ нь хоёр улсын худалдааны түүхэн харилцаа хэвээр байгаа ч харьцангуй тогтвортой, шинэ өсөлт багатайг харуулж байна. Мөн Зүүн Өмнөд Азийн орнуудын зах зээлд экспортын хэмжээ нэмэгдэж байгаа бөгөөд 2023 онд 256.4 сая ам.долларт хүрсэн нь бүс нутгийн зах зээлд Монголын экспортын бүтээгдэхүүн өргөжиж байгааг харуулж байна.

Зураг 2.4 Монгол Улсын импортын хэмжээ (улсаар)



Эх сурвалж: 1212.mn, 2023

Импортын тоо баримт, графикаас харахад Хятад улс Монголын импортын гол түнш хэвээр байгаа нь 2019-2023 оны хооронд тасралтгүй давамгайлж, 2023 онд 3.77 тэрбум ам.долларт хүрсэн байна. Энэ нь Монгол Улс Хятадаас аж үйлдвэрийн болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнээ их хэмжээгээр хамаарч байгааг харуулж байна. Мөн ОХУ 2023 онд 2.39 тэрбум ам.долларын импорттойгоор эрчим хүч, түүхий эдийн стратегийн чухал нийлүүлэгч байгааг харууллаа. Европын холбооноос 2023 онд 814 сая ам.долларын импорт хийсэн нь өндөр чанартай барааны зах зээлд чухал байр суурь эзэлж

байгааг илтгэнэ. Харин БНСУ-аас 415 сая ам.доллар, АНУ-аас 280 сая ам.долларын импорт хийсэн нь Монгол Улс тусгайлсан, дэвшилтэт технологийн бүтээгдэхүүнд анхаарч байгааг илэрхийлж байна. Австрали, Зүүн Өмнөд Азийн бүс нутгаас хийсэн импорт харьцангуй бага хэвээр байгаа нь Монгол Улсын тодорхой худалдааны түншүүдээс хамаарал өндөр байгааг харуулж байна.

2.2 Арилжааны банкны гадаад төлбөр тооцоо

2024 оны байдлаар Монгол Улсын банкны салбарт нийт 11 банк үйл ажиллагаа явуулж, экспорт, импорт, зээлийн төлбөр, хөрөнгө оруулалтын шилжүүлэг зэрэг олон төрлийн гүйлгээг гүйцэтгэхдээ SWIFT олон улсын төлбөр тооцооны системийг түлхүү ашиглаж байна. 2023 оны байдлаар Монгол Улсын гадаад төлбөр тооцооны нийт дүн ойролцоогоор 4.6 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд валютын арилжаа, аккредив, инкасс, мөнгөн шилжүүлэг зэрэг гүйлгээний төрөл тус бүрд хуваагдан, тогтмол өсөлттэй байна. Гадаад төлбөр тооцооны 85% нь SWIFT сүлжээгээр дамжин гүйцэтгэгдэж, аккредитив болон инкассын аргыг экспорт, импортын салбарт төлбөр тооцоог өргөн ашиглаж байгаа нь бизнесийн чадавхыг нэмэгдүүлж байна.

Мөн түүнчлэн Монголбанк олон улсын хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд анхаарч, Монгол-Хятадын банк, санхүүгийн салбарын хамтын ажиллагааны уулзалт, “Монгол-Солонгосын хамтын ажиллагаа” эрдэм шинжилгээний хурлыг амжилттай зохион байгуулж, олон улсын төлбөр тооцооны банкны (BIS) дээд түвшний хурлуудад идэвхтэй оролцсон байна. Мөн Киргиз улсын банк хоорондын процессингийн төв, БНСУ-ын “БиСи Карт” зэрэг байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, БНХАУ-ын Макаогийн Санхүүгийн мэдээллийн албатай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан нь бүс нутгийн харилцааг бататгасан онцлох үйл явдал болсон юм. (Монголбанк,2023)

Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй 11 арилжааны банкнаас 2 нь гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхэлдэггүй ба үлдсэн 9 банк нь корреспондент банкны харилцаагаа өргөжүүлж, SWIFT системээр дамжуулан гүйлгээ хийж байна. Дэлгэрэнгүй корреспондент банкны мэдээллийг хавсралтад оруулав. Доорх хүснэгтэд эдгээр банкнуудын гадаад валютын дансны тоог харууллаа.

Хүснэгт 2.1 Арилжааны банкны гадаад гуйвуулга хийдэг валют болон корреспондент банкууд

№	Арилжааны банк нэр	Ам.доллар	Евро	Юань	Иен	Бусад	Нийт тоо
1	Худалдаа хөгжлийн банк	13	6	7	3	16	45
2	Голомт банк	14		8		23	45
3	Хаан банк	12	2	6	3	8	31
4	Хас банк	8	2	6	2	6	24
5	Төрийн банк	6	1	4	2	6	19

6	Капитрон банк	6	1	4	2	6	19
7	Тээвэр хөгжлийн банк	6	4	5	1	5	17
8	Богд банк	3	1	4		2	10
9	Ариг банк	2	2	3		1	8
10	Чингис хаан банк	-	-	-	-	-	-
11	М банк	-	-	-	-	-	-

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэлээр

Энэхүү хүснэгт нь Монгол Улсын системийн банкуудын гадаад төлбөр тооцооны корреспондент банкны валютын төрөл тус бүрийн харьцуулалтыг харуулж байна. Голомт банк болон Худалдаа хөгжлийн банк хамгийн олон корреспондент банктай харилцдаг байна. Хаан банк нь 31 корреспондент банктай, ихэнх гүйлгээ нь ам.доллар, юань болон еврогийн гүйлгээ давамгайлдаг. Хас банкны хувьд 24 корреспондент банктай харилцдаг бөгөөд ам.доллар болон юанийн валютаар төлбөр тооцоог шилжүүлдэг. Төрийн банк, Капитрон банк тус бүр 19 корреспондент банктай бөгөөд валютын төрөл багатай. Тээвэр хөгжлийн банк 17 корреспондент банктай, харин Богд банк, Ариг банкны корреспондент банкны тоо харьцангуй цөөн, валютын төрөл ч мөн хязгаарлагдмал байна. Томоохон банкууд гадаад валютын төрөлд илүү өргөн хамрах хүрээтэй байгаа бол жижиг банкуудын гадаад төлбөр тооцооны хүртээмж хязгаарлагдмал байна.

SWIFT (GPI) нь олон улсын гүйлгээний хурдыг нэмэгдүүлж, ил тод байдлыг хангах зорилгоор SWIFT байгууллагаас боловсруулсан шинэчлэл юм. Энэ систем нь гүйлгээний явцыг бодит цаг хугацаанд хянах, шимтгэл болон нэмэлт төлбөрийн мэдээллийг ил тод харуулах боломжийг олгодгоороо онцлогтой. Дэлхий даяар олон банк SWIFT GPI-г нэвтрүүлж, гадаад төлбөр тооцоог илүү хялбар, найдвартай болгож байна. Доорх хүснэгтэд арилжааны банкнуудын SWIFT (GPI) нэвтэрсэн талаарх судалгааг харууллаа.

Хүснэгт 2.2 Арилжааны банкнуудын SWIFT (GPI) нэвтрүүлсэн байдал

№	Арилжааны банк нэр	Нэвтэрсэн	Нэвтрээгүй	Нэвтрэх бэлтгэл ажил явагдаж байгаа
1	Худалдаа хөгжлийн банк	(+)		
2	Голомт банк	(+)		
3	Хаан банк	(+)		
4	Төрийн банк	(+)		
5	Хас банк	(+)		
6	Тээвэр хөгжлийн банк		(+)	
7	Чингис хаан банк		(+)	
8	Капитрон			(+)
9	Богд банк			(+)
10	Ариг банк	(+)		
11	М банк		(+)	

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэлээр

Монголын арилжааны банкнуудад SWIFT GPI-ийн нэвтрэлт харилцан адилгүй байгааг дээрх хүснэгтээс харж болно. Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Хаан банк, Хас банк, Төрийн банк зэрэг томоохон банкнууд SWIFT GPI системийг бүрэн нэвтрүүлсэн. Түүнчлэн Ариг банк энэхүү системийг амжилттай нэвтрүүлж, үйлчлүүлэгчдийн гадаад төлбөр тооцооны хурд, ил тод байдлыг сайжруулан ажиллаж байна. Харин Богд банк, Капитрон банк зэрэг банкнууд SWIFT GPI нэвтрүүлэх шатандаа явж байгаа нь системийг бүхэлд нь нэвтрүүлэхэд цаг хугацаа, нөөц шаардлагатайг харуулж байна. Арилжааны банкнууд SWIFT GPI-ийг нэвтрүүлснээр гадаад төлбөр тооцооны системийн чанарыг олон улсын түвшинд хүргэж, Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлж байна. Гэхдээ системийг бүх банкнууд бүрэн нэвтрүүлэх нь чухал бөгөөд энэ нь гадаад төлбөр тооцооны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, дэд бүтцийг бэхжүүлэх үндэс суурь болно.

SWIFT GPI арилжааны банкнуудад дараах нөлөөг үзүүлж байна. Үүнд:

- Хурд: Гүйлгээний хугацаа багасаж, олон улсын бизнесийн гүйлгээг илүү шуурхай болгож байна.
- Итгэлцэл: Гүйлгээний явцыг хянах, ил тод мэдээлэл авах боломжтой тул харилцагчдын итгэл нэмэгдсэн.

- Хөрвөх чадвар: Гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаа илүү үр ашигтай, найдвартай болох зэрэг орно.

SWIFT системээс гадна арилжааны банкнууд Visa B2B, Western Union, Moneygram гэх төлбөрийн хэрэгслүүдийг нэвтрүүлж байна. Эдгээр төлбөрийн хэрэгслүүд нь банкны харилцагчдад илүү олон төрлийн сонголт өгч гүйлгээг илүү хялбар, шуурхай болгох, харилцагчдын хэрэгцээг хангах чиглэлээр чухал үүрэг гүйцэтгэж байна. Доорх хүснэгтэд арилжааны банкнуудын гадаад төлбөр тооцооны хэрэгслийн нэвтрүүлсэн байдлыг харууллаа.

Хүснэгт 2.3 Банкнуудын гадаад төлбөр тооцооны төрөл нэвтрүүлсэн байдал

Банкууд	Visa B2B	Валют арилжаа	SWIFT	Western Union	Money gram	Pay easy	QBS	P2P
ХХБ	(+)	(+)	(+)		(+)	(+)	(+)	(+)
Голомт	(+)	(+)	(+)	(+)	(+)			
Хаан			(+)	(+)				
Төр			(+)	(+)				
Хас			(+)					
Тээвэр хөгжил			(+)					
Чингис хаан банк								
Капитрон банк	(+)		(+)		(+)			
Богд банк			(+)					
Ариг банк			(+)		(+)			
М банк								

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэлээр

Зохицуулагч байгууллагын үүрэг оролцоо (Монголбанк)

Монголбанк нь арилжааны банкуудын гадаад төлбөр тооцооны тогтвортой байдал, найдвартай байдлыг хангах үүрэгтэй. Энэ хүрээнд гадаад валютын нөөцийн удирдлага, валютын ханшийн тогтвортой байдлыг хангах, валютын зах зээлийн зохицуулалт зэрэг чиглэлээр бодлого хэрэгжүүлдэг. 2023 оны байдлаар Монголбанкны гадаад валютын нөөц 4.9 тэрбум ам.долларт хүрсэн нь нийт гадаад төлбөрийн 70 орчим хувийг хангах боломжтой үзүүлэлт бөгөөд энэ нь арилжааны банкуудын гадаад төлбөр тооцооны найдвартай байдлыг баталгаажуулах үндсэн эх үүсвэр болдог. Мөн Монголбанк нь арилжааны банкуудад валютын эрсдэлээс хамгаалах зорилгоор своп болон форвард гэрээгээр ханшийн эрсдэлийг бууруулах боломжийг олгож, валютын арилжааны зохицуулалтад хяналт тавьж, олон улсын стандартын дагуу үйл ажиллагааг нь чиглүүлдэг.

Монголбанкны гадаад төлбөр тооцооны хүрээ нь жил бүр нэмэгдэж, үндэсний төлбөрийн системийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж байна. Монголбанк нь олон улсын төлбөр тооцооны системд оролцож, гадаадын банкуудтай холбогдон, тухайн улс орнуудын төлбөрийн гүйлгээг хянадаг байгууллага юм. Монголбанк Үндэсний төлбөрийн системийг (ҮТС) удирдаж, гадаад төлбөр тооцооны санхүүгийн харилцааг зохицуулж, илүү автоматжуулсан гүйлгээний нөхцөлийг хангах чиглэлээр олон арга хэмжээ авч байна.

Монголбанкны гадаад төлбөр тооцооны захиралтай хийсэн ярилцлагаас:

2022 оны 3 дугаар сараас эхлэн Монголбанк нь ОХУ-д тавигдсан олон улсын хориг арга хэмжээнүүдтэй холбоотойгоор тус улстай хийх гадаад төлбөр тооцооны арга замуудыг судалж эхэлжээ. ОХУ-ын эсрэг АНУ, Европын Холбоо зэрэг орнуудаас эдийн засгийн хориг арга хэмжээ авсан нь Монгол Улсын банк санхүүгийн салбарт шууд нөлөөлж, ОХУ-тай хийх гүйлгээг удаашруулж, тодорхой сорилтуудыг үүсгэсэн. Монгол Улс хуулиндаа НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шийдвэрийг дагаж мөрдөх үүрэгтэй ч, ОХУ нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн тул тус улсад НҮБ-аас хориг тавих боломжгүй гэж үздэг. Энэ нөхцөлд томоохон банкнууд нэр хүндийн эрсдэл болон ханшийн зөрүүний эрсдэлээс зайлсхийхийн тулд ОХУ руу гүйлгээ хийхээс татгалзах байдал үүссэн. Монголбанк нь ОХУ-тай хийх гүйлгээг зохицуулах онцгой нөхцөл бүхий гэрээ байгуулах, эсвэл улс орноо эдийн засгийн хоёрдогч хоригт орохоос сэргийлэх өөр шийдлүүдийг судалж байна. 2024 оны 3-р улиралын байдлаар 3 төрлийн ерөнхий

лицензээр хүнс, эм, нефт гэх 3 төрлөөр төлбөр тооцоог АНУ-ын бус, хориг арга хэмжээнд ороогүй байгууллагаар дамжуулан гүйцэтгэхийг зөвшөөрсөн.

2.3 Олон улс дахь гадаад төлбөр тооцоо (кейс судалгаа)

Казахстан улсын гадаад төлбөр тооцоо

Казахстан улсыг судалгааны эхний кейс болгон сонгосон шалтгаан нь Монгол Улстай олон талаар төстэй байдалтай холбоотой. Хоёр улс эдийн засгийн бүтэц, хөгжлийн түвшний хувьд төстэй, уул уурхай болон хөдөө аж ахуй голлох салбарууд бөгөөд гадаад худалдаа, санхүүгийн системд ижил төстэй сорилтуудтай тулгардаг. Мөн Төв Азид оршиж, Хятад болон Орос улстай хил залгадаг нь бүс нутгийн худалдааны интеграци болон гадаад төлбөр тооцооны системийн хараат байдлыг багасгах хэрэгцээг бий болгож байна. Казахстан улс Евро Азийн Эдийн Засгийн Холбоо болон Хятадын CIPS системтэй хамтран гадаад төлбөр тооцооны бие даасан байдлыг хангах зэрэг олон шийдлийг судалж, хэрэгжүүлж байгаа нь Монгол Улсад жишиг болохуйц туршлага болж байна. Иймээс Казахстан улсын туршлагыг судалснаар Монгол Улсын гадаад төлбөр тооцооны системийг хөгжүүлэх боломжийг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

Казахстаны Төв банк нь валютын ханшийг зохицуулж, банкнууд өөр хоорондоо болон харилцагчдын өмнөөс валют арилжааны гүйлгээ хийж, олон улсын санхүүгийн урсгалыг дэмждэг. Олон улсын гүйлгээндээ SWIFT, MoneyGram, Western Union, Golden Crown зэрэг төлбөрийн системүүдийг ашиглаж байна. Мөн газарзүйн байршлын онцлогийг ашиглан худалдааны үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор Евро Азийн Эдийн Засгийн Холбооны шинэ төлбөрийн системүүдийг судалж, гадаад системүүдээс хараат байдлаа багасгаж, хөрш орнуудтайгаа төлбөрийн системийг нэгтгэхээрр ажиллаж байна. Казахстан нь гадаад худалдааны төв байршилтай тул импорт, экспортын эрсдэлээ бууруулахын тулд аккредитив, банкны баталгаа, инкассо зэрэг төлбөрийн хэрэгслүүдийг өргөн ашигладаг.

Тус улсын томоохон арилжааны банкнууд болох Halyk Bank, Jusan Bank нь АНУ-ын Citibank, Европын Societe Generale, Германы Ziraat Bank International, ОХУ-ын Sberbank, Хятадын Bank of China Kazakhstan, Туркийн Türkiye Cumhuriyeti Ziraat Bankasi зэрэгтэй корреспондент банкны харилцаа тогтоосон нь Казахстаны эдийн засгийн глобал интеграцийг дэмжиж, олон улсын худалдааг хялбаршуулах чухал механизм болдог.

Казахстан улс гадаад төлбөр тооцооны системээ шинэчлэх, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлд олон улсын болон дотоодын шийдлүүдийг амжилттай хэрэгжүүлсэн. Тус улс Евро Азийн Эдийн Засгийн Холбоо, Хятадын CIPS зэрэг системүүдтэй хамтран ажиллаж,

валютын хараат байдлыг бууруулж, гүйлгээний хурд, санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлэн, тогтвортой байдлыг хангах чухал алхам хийжээ. Эдгээр өөрчлөлтүүдийн үр дүнд Казахстан улс гадаад төлбөр тооцооны үр ашгийг 20%-аар нэмэгдүүлж, бүс нутгийн худалдааны интеграцид чухал хувь нэмэр оруулсан. Жишээлбэл, 2022 оны статистик мэдээллээс үзэхэд, Казахстан-Хятадын хооронд хийгдсэн нийт гүйлгээний 35% нь юаниар хийгдсэн нь CIPS системийн ач холбогдлыг тодотгож байна.

Сингапур улсын гадаад төлбөр тооцоо

Сингапур улсыг судалгааны кейс болгон сонгосон шалтгаан нь тус улсын санхүүгийн системийн өндөр хөгжил, гадаад төлбөр тооцооны дижиталчлалын амжилт, мөн бүс нутгийн эдийн засгийн интеграцид оруулсан хувь нэмэртэй холбоотой. Сингапур улс нь Ази, Номхон далайн бүс нутгийн санхүүгийн төв гэдгээрээ онцлог бөгөөд SWIFT, CIPS, PayNow, SGQR зэрэг олон улсын болон үндэсний дижитал төлбөр тооцооны системийг амжилттай ашиглаж байна. Түүнчлэн тус улсын нэгдсэн SGQR систем, банк хоорондын шуурхай гүйлгээг дэмждэг PayNow платформ нь төлбөр тооцооны хурд, зардлын үр ашгийг сайжруулж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд онцгой нөлөө үзүүлсэн. Дэлхийд Сингапурын гадаад төлбөр тооцооны систем нь дижитал технологийг өргөнөөр ашиглаж, бүс нутгийн худалдаа, эдийн засгийн интеграцад чухал хувь нэмэр оруулсан туршлагатай. Тус улсын кейсийг судалснаар Монгол Улсад дижитал төлбөр тооцооны системийг хөгжүүлэх, гадаад худалдааны санхүүжилтийг оновчтой болгох, зардлыг бууруулах боломжийг тодорхойлох ач холбогдолтой юм.

Сингапурын Төв банк буюу Сингапурын Санхүүгийн Зохицуулах Газар (MAS) нь улс орны валютын ханшийг зохицуулж, олон улсын санхүүгийн урсгалыг тогтвортой байлгах үүрэгтэй. Сингапур улс гадаад төлбөр тооцооны системдээ SWIFT, PayNow, CIPS, MAS Electronic Payment System (MEPS+) өргөнөөр ашиглаж байна. Эдгээр системүүд нь банк хоорондын гүйлгээг хурдан, аюулгүй байдлаар гүйцэтгэх боломжийг олгодог. (MAS.gov.sg)

Сингапурын банкнууд нь олон улсын томоохон санхүүгийн байгууллагуудтай корреспондент харилцаа тогтоосон бөгөөд үүнд АНУ-ын Citibank, Европын Deutsche Bank, Японы Mitsubishi UFJ Bank, мөн Хятадын Bank of China зэрэг багтдаг. Энэ нь Сингапурыг дэлхийн санхүүгийн төв болгох, олон улсын худалдааны гүйлгээг дэмжих чухал хүчин зүйл болж байна.(abs.org.sg)

2023 оны байдлаар Сингапурын санхүүгийн байгууллагууд 160 гаруй оронтой харилцаатай ажиллаж, нийт төлбөрийн картыг 10 сая хэрэглэгч ашиглаж байна. SGQR (Singapore Quick Response Code)-ийн систем нь дотоодын болон хил дамнасан төлбөр тооцоог хялбаршуулахад томоохон үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд дижитал гүйлгээний эзлэх хувь 75%-д хүрчээ. Энэхүү дэвшил нь Сингапурыг бүс нутгийн болон олон улсын санхүүгийн интеграцийн жишиг улс болгож, дижитал төлбөр тооцооны хүртээмжийг өргөжүүлж байна.(fintechnews.sg)

Paynow систем

Сингапурын Paynow системийг бүс нутгийн төлбөрийн системүүдтэй холбосноор хил дамнасан төлбөр тооцооны хүртээмж, хурд, үр ашгийг нэмэгдүүлэхэд чухал алхам болж байна. 2021 онд Тайландын PromptPay системтэй, 2022 онд Малайзын DuitNow системтэй холбогдсоноор тус улсын иргэд гар утасны дугаар ашиглан, бодит цагийн горимд төлбөр тооцоо хийх боломжтой болжээ. Энэ нь бүс нутгийн санхүүгийн интеграцид томоохон ахиц авчирч, төлбөрийн шимтгэлийг бууруулан, хэрэглэгчдэд хямд, хялбар үйлчилгээг үзүүлж эхэлсэн.(Dollars and sense, the straits times) PromptPay системтэй холбогдсон нь дэлхийд анхдагч болж, Тайланд-Сингапурын хооронд мөнгөн шилжүүлгийг шууд гүйцэтгэх боломжийг бүрдүүлсэн. Үүний нэгэн адил, DuitNow системтэй холболт нь Сингапур, Малайзын иргэдийн санхүүгийн үйлчилгээг хялбаршуулж, QR код эсвэл гар утасны дугаар ашиглан хил дамнасан төлбөр хийхэд чиглэгдсэн байна.

Project Nexus

“Нексус төсөл” нь Олон улсын төлбөр тооцооны банк (BIS)-ын Инновацын төвөөс санаачилсан, дэлхийн дотоодын шуурхай төлбөрийн системүүдийг (IPS) холбох замаар хил дамнасан төлбөр тооцоог өөрчлөх зорилготой төсөл юм. Энэхүү төслийн үндсэн зорилго нь янз бүрийн үндэсний төлбөрийн системүүдийн холболтыг стандартчилах замаар хил дамнасан төлбөр тооцоог шуурхай, хямд, ил тод болгоход оршдог.

2024 оны 7-р сард Нексус төсөл нь хэд хэдэн дотоодын IPS-ийг холбох хүрээний нарийвчилсан төлөвлөгөөг амжилттай боловсруулж дууссан. Энэхүү төлөвлөгөө нь улс орнуудад хил дамнасан төлбөрийн үйлчилгээг шуурхай нэвтрүүлэхэд тулгарч буй бэрхшээлүүдийг шийдвэрлэх гарын авлага болох юм. Энэтхэг, Малайз, Филиппин, Сингапур, Тайландын төв банкнууд төслийн үүсгэн

байгуулагч гишүүдээр нэгдсэн бол Индонези ажиглагчаар оролцож байна. Төслийг хэрэгжүүлэх зорилгоор эдгээр төв банкнууд Сингапурт Нексусын хөтөлбөрийн байгууллага (NSO) байгуулахаар тохиролцсон бөгөөд BIS нь зөвлөхийн үүрэг гүйцэтгэнэ.(Thestar.com.my)

Дотоодын IPS-үүдийг холбосноор хил дамнасан төлбөрийг 60 секундээс бага хугацаанд гүйцэтгэх боломжтой болж, уламжлалт аргаас илүү хурдан болгож байна. Мөн энэхүү төсөл нь G20-ийн хил дамнасан төлбөр тооцоог сайжруулах замын зураглалтай нийцэж, 2027 он гэхэд төлбөрийн дундаж зардлыг 1%-аас ихгүй түвшинд байлгах аар зорьж байна. Үүнээс гадна, Нексус нь төлбөрийн ил тод байдлыг сайжруулж, дэлхийн хэрэглэгчдэд илүү хүртээмжтэй санхүүгийн үйлчилгээг бий болгож байна. (Bis.org)

CIPS систем

Сингапурт хэд хэдэн санхүүгийн байгууллагууд CIPS системд нэгдэж, юанийн гүйлгээг хөнгөвчлөх чиглэлээр ажиллаж байна. Тухайлбал, Хятадын Үйлдвэр, Худалдааны Банк (ICBC)-ын Сингапур дахь салбар уг системийг нэвтрүүлэхэд идэвхтэй оролцжээ. 2015 оны 10-р сард ICBC Сингапур нь CIPS системээр дамжуулан 35 сая юанийн гүйлгээ хийж, энэ нь уг системийг эрт хэрэгжүүлсэн томоохон амжилт болсон юм. Мөн DBS Банк, Сингапурын тэргүүлэх санхүүгийн байгууллагын хувьд, 2015 оны 10-р сард CIPS системд анхны банкнуудын нэгээр нэгдэж, анхдагч жагсаалтад багтсан Сингапурын цорын ганц банк болжээ. Энэ нь DBS банкны хувьд хил дамнасан бүх юанийн гүйлгээнд цэвэрлэгээ хийх, Хятадад үйл ажиллагаа явуулдаг гадаадын банкнуудад ил тод байдлыг сайжруулах боломжийг бүрдүүлсэн. (Cips.org)

CIPS системд нэгдсэнээр Сингапурын санхүүгийн байгууллагууд хил дамнасан юанийн гүйлгээний үр ашгийг нэмэгдүүлж, Хятадын юанийг олон улсын хэмжээнд ашиглахад дэмжлэг үзүүлэн, Сингапур болон Хятадын эдийн засгийн харилцааг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулсан. CIPS-ийн нэвтрүүлэлт нь Сингапурын Хятадтай хийж буй худалдааг сайжруулж, юанийн гүйлгээний үр ашгийг нэмэгдүүлсэн.

Хятад улсын гадаад төлбөр тооцоо

Хятад улсыг судалгааны кейс болгон сонгосон шалтгаан нь дэлхийн санхүүгийн салбарт тэргүүлэх үүрэг гүйцэтгэж буй болон олон улсын төлбөр тооцооны системд шинэлэг арга барилыг нэвтрүүлж байгаа явдал юм. Дэлхийн хоёр дахь том эдийн засаг, олон улсын худалдааны гол тоглогчийн хувьд Хятад улс Банк хоорондын хилийн чанадын төлбөр тооцооны систем (CIPS) зэрэг орчин төлбөр тооцооны дэд бүтцийг хөгжүүлж, уламжлалт платформ болох SWIFT-ийг шууд сорьж байна.

Хятад улс үндэсний валют болох юанийг (RMB) олон улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлэхэд анхаарч, CIPS болон дэлхийн санхүүгийн томоохон төвүүдэд юанийг цэвэрлэх банкнуудыг байгуулсан нь тус улсын худалдааны гүйлгээнд ам.доллар болон еврогийн хамаарлыг бууруулах томоохон алхам болсон.

Хил дамнасан банк хоорондын төлбөрийн систем (CIPS)

2015 онд Хятадын Ардын Банкнаас (PBoC) нэвтрүүлсэн CIPS систем нь юанийг олон улсын хэмжээнд ашиглах стратегийн үндэс болж байна. Тус систем нь хил дамнасан юанийн гүйлгээний цэвэрлэгээ, тооцоог хялбарчилдаг. 2024 оны байдлаар CIPS-д дэлхийн 110 орны 1300 гаруй санхүүгийн байгууллага нэгдээд байна. Энэхүү сүлжээ нь гүйлгээний хугацааг богиносгож, зардлыг бууруулан Хятад болон дэлхийн түншүүдийн хооронд худалдаа, санхүүгийн харилцааг бэхжүүлж байна. CIPS систем нь “Бүс ба Зам” санаачилгад (BRI) оролцогч орнуудад тогтвортой, үр ашигтай санхүүгийн дэд бүтэц бий болгож байна. (People’s bank of china, swift insights)

Юанийн тооцооны банкнууд

Хятад улс Лондон, Франкфурт, Сингапур, Хонг Конг зэрэг дэлхийн санхүүгийн төвүүдэд юанийн тооцооны банкнуудыг байгуулж, оффшор зах зээлд юанийн гүйлгээг хөнгөвчилж, санхүүгийн урсгалыг сайжруулж байна. (Bank of china)

Европын холбооны гадаад төлбөр тооцоо

Европын Холбоо нь дэлхийн эдийн засгийн хамгийн нэгдмэл бүс нутгийн нэг бөгөөд гадаад төлбөр тооцооны нэгдсэн, өндөр үр ашигтай системийг хөгжүүлснээрээ онцлог юм. TARGET2, TIPS зэрэг системүүд нь хил дамнасан төлбөр тооцооны хурд, аюулгүй байдлыг дэмжихээс гадна SEPA-ийн хүрээнд жижиглэнгийн төлбөрийн үр ашгийг нэмэгдүүлсэн. Европын холбооны туршлагыг судалснаар Монгол Улс олон улсын төлбөр тооцооны системээ хөгжүүлэх, худалдааны интеграцид хувь нэмэр оруулах, зардал хэмнэх шийдлүүдийг тодорхойлох боломжтой.

TARGET2 (Европын автоматжуулсан шуурхай төлбөрийн систем)

TARGET2 нь ЕХ-ны бодит цагийн төлбөрийн систем бөгөөд Европын Төв Банкнаас ажиллуулдаг. Энэ нь том хэмжээний еврогийн төлбөрийг бодит цаг хугацаанд, эцсийн байдлаар зохицуулж, шуурхай гүйцэтгэдэг. 2024 оны байдлаар TARGET2 өдөрт 2.2 их наяд еврогийн гүйлгээг боловсруулж, ЕХ-ны санхүүгийн дэд бүтцийн чухал хэсэг болж байна. (en.wikipedia.org)

TIPS (TARGET Шуурхай Төлбөрийн Систем)

2018 онд эхэлсэн TIPS нь еврогийн шуурхай төлбөрийг 24/7 горимоор гүйцэтгэх боломжийг олгодог. Энэ нь хувь хүн, байгууллагуудад Европ даяар шуурхай шилжүүлэг хийх боломжийг олгож, жижиглэнгийн төлбөрийн хурд, үр ашгийг нэмэгдүүлж байна. 2024 оны 10-р сард Европын Төв Банк TIPS-ийг бусад шуурхай төлбөрийн системүүдтэй холбох шинэ санаачилга зарлаж, ЕХ дотор болон хил дамнасан төлбөрийг хөнгөвчлөхөөр ажиллаж байна. ([Ecb.europa.eu](https://ecb.europa.eu))

SEPA (Евро бүсийн төлбөрийн нэгдсэн орон зай)

SEPA нь Европ даяарх еврогийн цахим төлбөрүүдийг нэгтгэж, хил дамнасан төлбөрийг дотоод төлбөртэй адил хялбар болгосон. Энэ нь зээлийн шилжүүлэг, шууд дебит, картын төлбөрийгfi хамардаг ба хэрэглэгч, байгууллагуудад гүйлгээ хийх үйл явцыг энгийн болгодог. ([Finance.ec.europa.eu](https://finance.ec.europa.eu))

SWIFT нь зөвхөн ЕХ-нд ашиглагддаггүй ч Европын санхүүгийн байгууллагуудын дунд өргөнөөр хэрэглэгддэг. Энэ нь төлбөрийн заавар, мэдээллийг найдвартай, стандартчилагдсан байдлаар дамжуулахад чухал үүрэгтэй. Мөн ЕХ-ны дэлхийн санхүүгийн системтэй холбогдох гол механизм юм. ([Swift.com](https://swift.com))

АНУ-ын гадаад төлбөр тооцоо

АНУ-ыг судалгааны кейс болгон сонгосон шалтгаан нь тус улсын дэлхийн санхүүгийн системд эзлэх онцгой байр суурь, шинэлэг технологи, олон улсын гүйлгээний зохицуулалт, мөн долларын ноёрхолд оршиж байна. АНУ нь санхүүгийн технологийн дэвшлийг амжилттай нэвтрүүлж, дэлхийн хэмжээний банк хоорондын төлбөрийн систем, SWIFT, Fedwire, CHIPS зэрэг системүүдийг хөгжүүлж, гадаад худалдаа, хөрөнгө оруулалтад чухал хувь нэмэр оруулж байна. АНУ-ын туршлагыг судлах нь Монгол

Улсад гадаад төлбөр тооцооны дэд бүтцийг сайжруулж, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм.

АНУ-ын төлбөр тооцооны системүүд нь олон улсын болон дотоодын гүйлгээнд өндөр үр ашигтай, найдвартай ажиллагаатайгаараа онцлог юм. Жишээлбэл, SWIFT сүлжээг ашиглан дэлхийн санхүүгийн системтэй шууд холбогдох боломжийг хангаж байгаа бол Fedwire болон CHIPS системүүд нь өндөр дүнтэй гүйлгээний хурд, найдвартай байдлыг хангаж, өдөр тутмын олон тэрбум долларын гүйлгээг боловсруулж байна.

Fedwire

Fedwire бол АНУ-ын төв банкны бодит цагийн бэлэн мөнгөний гүйлгээний систем бөгөөд гадаад төлбөр тооцоонд шууд болон шууд бус байдлаар ашиглагддаг. Fedwire нь АНУ-ын Төв банкны удирдлага дор ажилладаг бодит цагийн төлбөрийн систем бөгөөд 2023 онд өдөрт дунджаар 3.5 их наяд ам.долларын гүйлгээг боловсруулсан. CHIPS (Clearing House Interbank Payments System) нь хувийн хэвшлийн удирдлагад байдаг бөгөөд АНУ-ын гадаад худалдааны 90 гаруй хувийг гүйцэтгэж, өдөр тутмын төлбөрийн гүйлгээгээрээ 1.7 их наяд ам.долларыг боловсруулж байна.

CHIPS

CHIPS (Clearing House Interbank Payments System) нь АНУ-ын томоохон банк хоорондын төлбөрийн систем бөгөөд их хэмжээний, өндөр ач холбогдолтой төлбөрийг найдвартай, үр ашигтайгаар зохицуулдаг. Энэхүү системийг The Clearing House байгууллага удирддаг бөгөөд өдөр бүр дунджаар 1.8 их наяд ам.долларын 500,000 орчим төлбөрийг боловсруулж, дэлхийн санхүүгийн урсгалд чухал үүрэг гүйцэтгэдэг. CHIPS нь 50 гаруй шууд гишүүн банктай бөгөөд эдгээр нь дэлхийн 180 гаруй орны төлбөр тооцоог зохицуулдаг өргөн сүлжээтэй. Систем нь неттинг зарчмыг ашиглан гүйлгээг зохицуулахад шаардагдах нийт нөөцийн хэмжээг бууруулж, өдөр тутмын гүйлгээний 95%-ийг цэвэршүүлдэг нь түүний үр ашигтай байдлыг харуулдаг.

2023 оны байдлаар CHIPS нь нийт 480 их наяд ам.долларын төлбөр боловсруулж, дундаж нэг гүйлгээний дүн 3.6 сая ам.доллар хүрсэн байна. Эдгээр гүйлгээний 40%-аас илүү хувь нь хил дамнасан төлбөр байсныг онцлох нь зүйтэй. Системийн дамжуулан хийгдсэн гүйлгээнүүдийн ихэнх нь олон улсын худалдаа, санхүүгийн гүйлгээний шуурхай байдлыг дэмжсэн бөгөөд дэлхийн санхүүгийн тогтвортой байдалд үнэтэй хувь

нэмэр оруулжээ. АНУ-ын дотоод болон олон улсын томоохон төлбөрийн хэрэгцээг хангах чухал систем болохын зэрэгцээ Монгол зэрэг хөгжиж буй орнуудад олон улсын төлбөр тооцооны шинэчлэлийг судлах, хэрэгжүүлэхэд жишиг болохуйц шийдэл байж чадна. Энэ системийн үр ашиг, хурд, технологийн дэвшлийг Монгол Улсын гадаад төлбөр тооцооны системд нэвтрүүлэх нь олон улсын интеграци болон худалдааны өрсөлдөх чадварыг сайжруулахад чухал нөлөө үзүүлэх юм. (CHIPS,2023)

2.4 CIPS болон CHIPS системийн процесс

CIPS (Хятадын төлбөр тооцооны систем) болон CHIPS (АНУ-ын төлбөр тооцооны систем)-ын гүйлгээний процесс, тэдгээр систем бусад улс орнуудад тавих шаардлагуудыг харьцуулсан мэдээллийг хүснэгт 10-т харууллаа. Энэхүү системүүдийн ажиллагааны үндсэн үе шатууд, зохицуулалтын нөхцөл, техникийн шаардлагуудыг харуулж, хэрэглээний цар хүрээг ойлгоход чиглэгдсэн.

Хүснэгт 2.4 CIPS болон CHIPS системийн процесс

CIPS	CHIPS
<i>Процесс</i>	<i>Процесс</i>
Гүйлгээ эхлэх <ul style="list-style-type: none"> - Гүйлгээний хүсэлт илгээх - Гүйлгээний мэдээллийг шалгах 	Гүйлгээ эхлэх <ul style="list-style-type: none"> - Төлбөрийн заавар дамжуулах - Гүйлгээний мэдээллийг шалгах
Гүйлгээг дамжуулах <ul style="list-style-type: none"> - CIPS сүлжээнд оруулах - Гүйлгээний өгөгдөл боловсруулах 	Гүйлгээний бүртгэл <ul style="list-style-type: none"> - CHIPS сүлжээнд бүртгэх - Төлбөрийн заавар хүлээн авах
Гүйлгээг зохицуулах <ul style="list-style-type: none"> - Тооцоолол хийх - Юанийн дансны ашиглалт - Бодит цагийн тооцоо 	Гүйлгээг боловсруулах <ul style="list-style-type: none"> - Нэттинг процесс ашиглах (өдөр тутамд оролцогч банкуудын олон төлбөрийг нэгтгэж, сөрөг дүнг тооцоолж, зөвхөн цэвэр дүнгээр төлбөрийг гүйцэтгэхийг хэлнэ.) - Эцсийн төлбөр баталгаажуулалт
Гүйлгээг хүлээн авах <ul style="list-style-type: none"> - Хүлээн авагчийн банкны мэдээлэл хүлээн авах - Мэдэгдэл өгөх 	Эцсийн тооцоо <ul style="list-style-type: none"> - Дансны тохиргоо - Бодит цагийн тохиролцооны горим
Төлбөрийн гүйлгээг хянах <ul style="list-style-type: none"> - Гүйлгээний ил тод байдал 	

<ul style="list-style-type: none"> - Тайлан гаргах <p>Тусгай процессууд</p> <ul style="list-style-type: none"> - Олон улсын шилжүүлэг - Буцаалт эсвэл гүйлгээний өөрчлөлт 	<p>Гүйлгээний баталгаажуулалт</p> <ul style="list-style-type: none"> - Төлбөрийг баталгаажуулах - Тайлан гаргах <p>Тусгай тохиолдлууд</p> <ul style="list-style-type: none"> - Гүйлгээг буцаах - Гүйлгээний дараалал
<p><i>Бусад улс оронд тавигддаг шаардлага</i></p> <p>Эрх зүйн шаардлага</p> <ul style="list-style-type: none"> - Лицензтэй байх - AML/KYS бодлогыг мөрдөх (Мөнгө угаахтай тэмцэх хууль болон үйлчлүүлэгчээ таних бодлогийг хэрэгжүүлсэн байх) - Хар жагсаалтанд ороогүй байх - Хятадын ардын банкны зүгээс тогтоосон бүх журмыг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэхэд бэлэн байх <p>Санхүүгийн шаардлага</p> <ul style="list-style-type: none"> - Санхүүгийн тогтвортой байдал - Хятад дахь төлбөр тооцооны данстай байх - Корреспондент банкны харилцаа <p>Техникийн шаардлага</p> <ul style="list-style-type: none"> - SWIFT-д холбогдох (CIPS нь SWIFT сүлжээгээр дамжуулан мэдээлэл солилцдог тул оролцогч банкууд SWIFT-д холбогдсон байх шаардлагатай) - Мэдээллийн системийн нийцэмж (ISO 20022 стандартын дагуу мэдээлэл солилцох боломжтой байх) 	<p><i>Бусад улс оронд тавигддаг шаардлага</i></p> <p>Эрх зүйн шаардлага</p> <ul style="list-style-type: none"> - Лицензтэй байх - AML/KYS бодлогыг мөрдөх (Мөнгө угаахтай тэмцэх хууль болон үйлчлүүлэгчээ таних бодлогийг хэрэгжүүлсэн байх) - АНУ-ын OFAC-ийн хориг арга хэмжээг хүлээн зөвшөөрөх <p>Санхүүгийн шаардлага</p> <ul style="list-style-type: none"> - Санхүүгийн тогтвортой байдал - Нөөцийн бодлого - Гарын үсэг бүхий баталгаат харилцаа <p>Техникийн шаардлага</p> <ul style="list-style-type: none"> - SWIFT-д холбогдох (CHIPS нь SWIFT сүлжээгээр дамжуулан мэдээлэл солилцдог тул оролцогч банкууд SWIFT-д холбогдсон байх шаардлагатай) - Дотоод мэдээллийн системийн чадамж сайн байх - Техникийн багтай байх <p>Эрсдлийн удирдлагийн шаардлага</p> <ul style="list-style-type: none"> - Эрсдлийн хяналт - Гүйлгээний хяналт - Холбогдох хууль тогтоомжинд нийцэх

<ul style="list-style-type: none"> - Кибер аюулгүй байдлын шаардлагыг хангах технологи, системтэй байх - Техникийн багтай байх <p>Гүйлгээний шаардлага</p> <ul style="list-style-type: none"> - Юаниар гүйлгээ хийх сонирхолтой эсвэл шаардлагатай харилцагчтай байх - Оролцогч банкууд Хятадын ардын банкнаас тогтоосон хязгаарлалт дор байх ёстой - Гүйлгээний ил тод байдал <p>Зардлын шаардлага</p> <ul style="list-style-type: none"> - Нэгдлийн хураамж төлөх - Гүйлгээний шимтгэл - Үйлчилгээний төлбөр <p>Хамтын ажиллагааны шаардлага</p> <ul style="list-style-type: none"> - Хятадтай эдийн засгийн идэвхитэй харилцаатай байх - Хөрөнгө оруулагчдын итгэл - Хөрш болон стратегийн түншлэл <p>Гишүүнчлэлийн түвшин</p> <p>CIPS- д оролцогч банкуудыг шууд болон шууд бус оролцогчид гэж ангилдаг</p> <ul style="list-style-type: none"> - Шууд оролцогчид CIPS сүлжээнд ходбогдон гүйлгээг шууд удирдах эрхтэй банкууд - Шууд бус оролцогчид гүйлгээг шууд оролцогчдын тусламжтайгаар гүйцэтгэдэг банкууд 	<p>Нэмэлт шаардлага</p> <ul style="list-style-type: none"> - Корреспондент харилцаа - Хэлний болон үйлчилгээний дэмжлэг - Шууд оролцогч эсвэл шууд бус оролцогч <p>Шимтгэл болон зардал</p> <ul style="list-style-type: none"> - Нэгдлийн хураамж - Гүйлгээний хураамж - Сар тутмын үйлчилгээний төлбөр
---	---

Эх сурвалж: CIPS ,CHIPS

2023 оны байдлаар CIPS систем нь дэлхийн 113 улс орон, бүс нутгаас 139 шууд оролцогч, 1345 шууд бус оролцогчтойгоор үйл ажиллагаа явуулж юаниар хийх төлбөр

тооцоо хялбар болж байна. Ихэнх оролцогчид Ази тивд төвлөрдөг. Харин CHIPS систем нь голчлон ам.доллароор гүйлгээ хийдэг бөгөөд шууд 41 оролцогчтой бөгөөд системийн гүйлгээний нийт 95%-ийг шууд оролцогчид боловсруулдаг. Эдгээр системүүд нь олон улсын төлбөр тооцоонд хувь нэмэр оруулж байна.

Бүлгийн дүгнэлт

Монгол Улсын арилжааны банкнууд гадаад төлбөр тооцооны үйлчилгээг олон улсын түвшинд хүргэх зорилт тавьж байгаа ч технологийн шинэчлэл, эрх зүйн зохицуулалтын хүрээнд бэрхшээлтэй хэвээр байна. Гадаад төлбөр тооцооны системийн хурд, аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд олон улсын туршлагаас суралцаж, Монголын нөхцөлд нийцүүлэх шаардлага бий. Монголын арилжааны банкнуудын SWIFT GPI системийг нэвтрүүлэх явц харилцан адилгүй байгаа нь үүний жишээ юм. Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Хаан банк зэрэг томоохон банкнууд энэхүү системийг амжилттай нэвтрүүлсэн бол Богд банк, Капитрон банк зэрэг банкнууд одоогоор нэвтрүүлэх шатандаа явж байна. SWIFT GPI системийг бүрэн нэвтрүүлснээр гүйлгээний хурд нэмэгдэж, харилцагчдын итгэлцэл дээшлэх, мөн төлбөр тооцооны үйл ажиллагааг илүү үр ашигтай, найдвартай болгох боломжтой.

Казахстан улс Евро Азийг холбосон төлбөрийн системийг хөгжүүлж, Хятад улсын CIPS системд холбогдсон нь SWIFT-ээс хараат байдлаа бууруулахад чиглэж байна. Энэ нь Монгол Улсад хэрэгжүүлж болохуйц туршлага юм. Мөн Сингапур улс PayNow болон SGQR зэрэг системийг амжилттай нэвтрүүлж, дижитал технологийн тусламжтайгаар төлбөр тооцооны хурд, хүртээмжийг нэмэгдүүлсэн нь Монгол Улсын хувьд сургаж болохуйц сайн туршлага болж байна. Хятад улс CIPS системийг ашиглаж, аюулгүй, хурдан төлбөр тооцоог ханган ажиллаж байгаа бол Европын Холбоо SEPA, TARGET2, TIPS зэрэг нэгдсэн системүүдийг нэвтрүүлэн эдийн засгийн интеграцид амжилттай хувь нэмэр оруулж байна. АНУ-ын хувьд Fedwire, CHIPS зэрэг системүүд нь олон улсын төлбөр тооцоог бодит цагийн горимоор, найдвартай зохицуулж байгаа нь Монголд үлгэр жишээ авч хэрэгжүүлэх боломжийг харуулж байна. Монгол Улс эдгээр системийн үйл ажиллагааны зарчим, туршлагыг судалж, төлбөр тооцооны системээ сайжруулснаар олон улсын түвшинд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх боломжтой.

Судалсан 5 улсын кейсийг харахад, улс бүр эхлээд стратегийн чухал ач холбогдолтой хөрш орнуудтайгаа хийх төлбөр тооцооны асуудлаа шийдвэрлэж, худалдааны саад бэрхшээлийг багасгасны дараа бусад улс орнуудтай хийх төлбөр тооцоонд анхаарлаа хандуулдаг нь ажиглагдлаа. Энэ нь хөрш орнуудтайгаа эдийн засгийн харилцааг бататгаж, бүс нутгийн интеграцийг нэмэгдүүлэх суурийг тавьж, цаашлаад дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвараа сайжруулах стратеги юм. Монгол Улс энэ туршлагыг өөрийн нөхцөлд хэрэгжүүлж, эхлээд ОХУ, БНХАУ зэрэг хөрш орнуудтайгаа төлбөр тооцооны системээ сайжруулж, дараа нь бусад олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах боломжийг эрэлхийлэх нь зүйтэй.

Ш БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Манай улсын системийн 10 арилжааны банкны гадаад төлбөр тооцооны системийг сайжруулах, инновацилаг шийдлээр хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг тодорхойлоход энэхүү судалгааны зорилго оршино. Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд дараах судалгааны аргуудыг ашиглана. Үүнд:

Хүснэгт 3.1 Судалгааны арга зүй

Баримт бичиг цуглуулах арга	Тухайн сэдэвтэй холбоотой дотоод болон гадаадад хийсэн судалгаа, олон улсын болон дотоодын банкны гадаад төлбөр тооцооны үүсэл хөгжлийг судалсан. Дотоодод хийсэн судалгаанд СЭЗИС-ийн мастерын зэрэг горилсон судалгааны ажлууд, дотоодын гадаад төлбөр тооцооны системийн нийт 10 банкны тайлан, судалгаа зэрэг багтана. Гадаадын улсуудаас Казахстан, Сингапур, Хятад, Европын холбоо, АНУ гэсэн 5 улсыг сонгон авч олон улсын төлбөр тооцооны системийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг холбогдох эх сурвалжуудаас цуглуулан үр дүн дээр нь анализ хийн судалсан болно.
Асуулгын арга	Арилжааны банкны гадаад төлбөр тооцооны чиглэлээр ажилдаг мэргэжилтнүүдээс өнөөгийн байдлыг тодорхойлох зорилгоор тандалтын судалгаа авсан. Үүнд теллер (10), аудитор (6), төлбөр тооцооны мэргэжилтэн (42), нягтлан (2), хэлтсийн захирал (4), захирал (1) хамрагдсан болно.
Кейс харьцуулсан шинжилгээний арга	Олон улсын гадаад төлбөр тооцооны хөгжлийн өнөөгийн чиг хандлагыг тодорхойлох зорилгоор нийтлэг 5 улсын кейсүүдийг судалж, тухайн улс орнуудын шинээр нэвтрүүлж буй хэрэгсэл, ашиглаж буй арга замуудыг хооронд нь харьцуулан дүгнэсэн.

Ярилцлагын арга	<p>Арилжааны банкнуудын гадаад төлбөр тооцооны өнөөгийн нөхцөл байдал, тулгарч буй асуудлууд, боломжуудыг тодорхойлох зорилгоор ярилцлага хийсэн. Үүнд гадаад гуйвуулгын мэргэжилтэн (2), гадаад төлбөр тооцооны хэлтсийн захирал (5), гүйцэтгэх захирал (2), гадаад төлбөр тооцооны газрын захирал (1) хамрагдсан болно. Мөн Монголбанкны гадаад төлбөр тооцооны газрын захирлаас гадаад төлбөр тооцоонд тулгамдаж буй асуудлуудын талаар ярилцсан болно.</p>
-----------------	--

Эх сурвалж: Судлаачийн эмхтгэл

IV БҮЛЭГ. СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ БА ҮР ДҮН

4.1 Арилжааны банкуудын гадаад төлбөр тооцооны өнөөгийн байдлыг үнэлэх нь

Энэхүү судалгааны ажлын зорилго нь манай улсын банкны системийн гадаад төлбөр тооцооны хэрэгслийг үнэлж, сайжруулах шаардлага байгаа эсэх мөн бусад төлбөрийн системд нэгдэхэд ямар асуудал тулгараад байгааг судлахыг зорин ажилласан ба банкнудаас асуулгын аргаар судалгаа авсан.

Арилжааны банкнуудын гадаад төлбөр тооцооны өнөөгийн нөхцөл байдал, тулгарч буй асуудлууд, боломжуудыг тодорхойлох зорилгоор банкны системийн 11 банкны хүмүүстэй ярилцлага хийсэн. Үүнд гадаад гуйвуулгын мэргэжилтэн (2), гадаад төлбөр тооцооны хэлтсийн захирал (5), гүйцэтгэх захирал (2), гадаад төлбөр тооцооны газрын захирал (1) хамрагдсан болно. Мөн Монголбанкны гадаад төлбөр тооцооны газрын захирал Э.Анараас гадаад төлбөр тооцоонд тулгамдаж буй асуудлуудын талаар ярилцсан болно.

Санал асуулгад Хаан банк, Худалдаа хөгжил, Голомт банк, Төрийн банк, Хас банк гэсэн 5 банкны гадаад төлбөр тооцооны газар, нэгж, хэлтэст ажилдаг хүмүүсээс судалгаа авсан. Үүнд теллер (10), аудитор (6), төлбөр тооцооны мэргэжилтэн (42), нягтлан (2), хэлтсийн захирал (4), захирал (1) гэх нийт 63 мэргэжилтэн оролцсон юм. Түүврийг сонгохдоо санаандгүй байдлаар биш зөвхөн олон улсын гүйлгээнд ямар нэгэн байдлаар оролцдог гэсэн албан хаагчид оролцсон нь хариулт харьцангуй бодитой үр дүнтэй гарахад нөлөөлсөн гэж үзэж байна. Санал асуулгын үр дүнгээс дүгнэхэд арилжааны банкны хувьд ОХУ-тай холбоотой Геополитикийн асуудлын дараа Монголбанкны гэнэтийн бодлого шийдвэр гаргалт нь гадаад төлбөр тооцоонд удаашрал үзүүлдэг байна.


Судалгаанд оролцсон мэргэжилтний 57% нь 5 жил энэ салбарт ажиллаж байгаа ба 5-10 жил 24% бол үлдсэн 19% нь энэ салбарт их дээд сургуулиа төгссөнөөсөө хойш тогтвортой удаан ажиллаж байгаа гэсэн байна. Мөн насны хувьд 25-30 насны залуучууд 10 хүрэхгүй хувийг эзэлж байгаа бол 31-35 болон 36 дээш насны ажилчид үлдсэн хувийг нь эзэлж байгаа нь энэ салбарт туршлагатай мэргэжилтэнүүд ажилладаг болохыг харуулж байна.

Судалгааны анкетанд 1 ерөнхий мэдээлэл, 2 бүлэг бүхий нийт 10 асуулт бүхий асуулгын судалгааг хийлээ. Судалгааны үр дүнг доор танилцууллаа.

Хүснэгт 4.1 Танай банкинд эдгээрээс гадаад төлбөр тооцоотой холбоотой ямар асуудлууд байгаа вэ?

Утга	Тоо, ш	Эзлэх хувь
Хэрэглэгчдэд тохирсон гадаад төлбөр тооцооны хэрэгсэл хангалтгүй	4	6.3
Гүйлгээ саатах	13	20.6
Комплайнсийн асуудал	7	11.1
Гадаад руу гүйлгээ хийх хэрэглэгчдийн тоо бусад банкуудтай харьцуулахад бага	6	9.5
ОХУ (Геополитикийн асуудал)	17	26.9
Шимтгэл өндрөөс болоод гүйлгээ хийх хэрэглэгчдийн тоо бага	0	0
Монголбанкны гэнэтийн бодлого шийдвэр гаргалт	14	22.2
Валютын ханшийн эрсдэл	2	3.2
Бүгд	63	100.0

Зураг 4.1 Танай банкинд гадаад төлбөр тооцоотой холбоотой ямар асуудлууд байгаа вэ?



Эх сурвалж: Судлаачийн эмхэтгэлээр

Эндээс харахад нийт оролцогчдын 27.0% нь ОХУ-ын геополитикийн асуудалтай байгаа нь дан ганц арилжааны банкнуудын асуудал биш улсын асуудал болох нь харагдаж байна. Үүний дараа 22.2% нь Монголбанкны гэнэтийн бодлого шийдвэр гаргалт байгаа нь шууд бусаар арилжааны банкнуудын үр ашиггүй байдалд нөлөөлж байна. Мөн Голомт банкны эксперттэй ярилцахад үүний талаар дурдаж байсан ба үүнд “Бид сар болгон, улирал болгон Монголбанк руу гадаад гүйлгээний тоон баримтаа явуулдаг. Заримдаа газар газраас нь өөр шаардлага тавиад уялдаа холбоогүй байдаг тал анзаарагдаж байсан” гэжээ.


Олон улсын карттай холбоотой тулгамдаж буй асуудлыг тодорхойлох зорилгын үр дүнг доор танилцууллаа.

Хүснэгт 4.2 Олон улсын карттай холбоотой ямар асуудал гарч байсан бэ?

Утга	Тоо, ш	Эзлэх хувь
Хэрэглэгч картын нууцлалаа алдсанаас гарсан асуудлууд	10	15.8
Картын брэндээс хамаарч олон улсад пос машин нь уншихгүй байх тохиолдолд ирсэн гомдол	19	30.1
Аюулгүйн байдлын үүднээс давхар баталгаажуулалт хийхэд хэрэглэгч анзаарахгүй өнгөрөх	25	39.6
Хэрэглэгч залиланд өртөөд гомдол гаргах	9	14.2
Нийт	63	100.0

Дээрх дүнг харахад оролцогчдын 39.7% нь аюулгүйн байдлын үүднээс давхар баталгаажуулалт хийхэд хэрэглэгч анзаарахгүй өнгөрөх болон 30.2% картын брэндээс хамааран олон улсад пос машин нь уншихгүй байх тохиолдолд ирсэн гомдлууд гэсэн байна. Өөрөөр хэлбэл, арилжааны банкнууд олон улсын картын систем, хэрэгслээ сайжруулах хэрэгтэй байна.

SWIFT-ээр хийх гүйлгээний асуудлыг тодорхойлох зорилгын үр дүнг доор танилцууллаа.




Зураг 4.2 SWIFT гүйлгээтэй холбоотой ямар асуудлууд гарч байсан бэ?

Эх сурвалж: Судлаачийн эмхэтгэлээр

Дээрх үр дүнг харахад нийт судалгаа өгсөн хүмүүсийн хагас хувь нь буюу 53% нь гүйлгээ саатах гэж судалгаа өгсөн байна. Энэ нь Европ, АНУ-аас тавьж байгаа хоригтой холбоотойгоор ОХУ-аас хүлээж авах, илгээх гүйлгээ удааширсан байгаатай холбогдолтой юм. 32% нь хэрэглэгч мэдээллээ дутуу, буруу андуурснаас болж гүйлгээ удааширах буцаагдах асуудалтай байна гэж бөглөсөн байна. Үлдсэн 15% нь SWIFT-ээс хараат байдал өндөр гэсэн байна.

“А” банкнаас SWIFT-ээр хийсэн гүйлгээний 2021-2024 оны 3 улирал хүртэлх тоон мэдээллийг авлаа. Доорх зурагт гүйлгээний тоон мэдээллийг харуулан дүгнэлээ.

Зураг 4.3 SWIFT-ээр хийсэн гүйлгээний тоо




Эх сурвалж: Судлаачийн эмхэтгэлээр

“А” банкнаас хамгийн их гүйлгээ хийгддэг гадаад төлбөр тооцооны систем болох SWIFT гүйлгээний тоог 2021-2024 оны 1-3 улирал хүртэлх тоо болон гүйлгээний тоог авлаа. Мэдээлэл өгсөн ажилтны дурдсанаар “ОХУ-тай холбоотойгоор манай банкны илгээсэн гүйлгээний тоо харьцангуй багассан ч гэсэн гүйлгээгээ тогтмол, аюулгүй хийхийг зорин ажиллаж байна” гэсэн. Түүнчлэн энэхүү гүйлгээнүүдийн 50%-аас илүү хувь нь Хятад улс руу илгээсэн болон хүлээн авсан гүйлгээ гэжээ. Энэхүү график дээрээс илгээсэн гүйлгээний тоо хүлээн авсан гүйлгээний тооноос давуу байгааг харуулж байгаа нь SWIFT системийг гадагшаа төлбөр тооцоо хийхэд ихээр ашиглаж байна.

Ярилцлагын аргаар банкны системийн 9 банкнаас гадаад гуйвуулга хийгддэг улсыг хувиар илэрхийлэн доорх зурагт үр дүнг танилцууллаа.

Зураг 4.4 Арилжааны 9 банкны гадаад гуйвуулга хийдэг улс хувиар (2023 он)

Эх сурвалж: Судлаачийн эмхэтгэлээр



Энэхүү графикаас харахад Монгол Улсын арилжааны банкнуудын гадаад төлбөр тооцооны чиглэлээр хийсэн судалгааны үр дүнг харуулж байна. Судалгаанд Чингис хаан банк болон М банк нь гадаад гүйлгээ хийдэггүй тул хамрагдаагүй. Үлдсэн 9 банкны гадаад төлбөр тооцооны ажилтнуудын өгсөн мэдээлэлд үндэслэн дүгнэсэн болно. Судалгааны үр дүнгээс харахад Капитрон банк, Ариг банк, Хаан банк, Хас банк, Богд банк зэрэг 5 банк ОХУ-аас бусад улс руу гүйлгээ хийх, хүлээн авах боломжтой байна. Арилжааны банкнуудын дийлэнх нь нийт гүйлгээний 50%-аас дээш хувийг Хятад улс руу гүйцэтгэж байгаа нь Хятадын худалдааны чухал түнш болохыг баталж байна. Харин ОХУ руу хийгдэж буй гүйлгээнүүд нь ихэвчлэн эм, эмнэлгийн хэрэгсэл, хүнс, түлш зэрэг хязгаарлагдмал хүрээнд явагдаж байгаа бөгөөд Ариг банк хамгийн их хувийг эзэлж байна. Энэ нь гадаад төлбөр тооцооны чиглэлээр банкнуудын гүйцэтгэх үүрэг, хамаарлын түвшнийг тодорхой харуулж байна.

4.2 Арилжааны банкны экспертүүдтэй хийсэн ярилцлагын үр дүн

Хүснэгт 4.3 Арилжааны 10 банкны экспертүүдтэй хийсэн ярилцлагын үр дүн

Арилжааны банк	Тулгамдсан асуудал	Сайжруулах боломж
----------------	--------------------	-------------------

<p>ХХБ</p>	<p>ОХУ-ын эсрэг барууны орнуудын тавьсан хориг арга хэмжээ нь гүйлгээнд саад учруулж байна.</p> <p>Арилжааны банкнуудад тавьдаг гадаад төлбөр тооцооны стандарт өндөр байхад финтек компаниудад харьцангуй зөөлөн шаардлага тавигддаг нь зохицуулалтын ялгааг үүсгэж байна. Энэ ялгааг багасгахын тулд банкнуудад тавигдах шаардлагыг бууруулах эсвэл финтек компаниудын хяналтыг сайжруулах хэрэгтэй гэж үзэж байна.</p>	<p>2024 онд ХХБ нь The Bank of New York Mellon байгууллагатай хамтран Монголын ам.долларын төлбөр тооцооны системийг дэлхийн зах зээлтэй шууд холбох томоохон шинэчлэлт хийсэн. Энэ нь гадаад валютын төлбөр тооцоог түргэн шуурхай, тогтвортой байдлаар хангах, дэлхийн түвшний банк санхүүгийн үйлчилгээ үзүүлэх чухал алхам болсон юм. Сүүлийн үед дэлхийн нийт банк санхүүгийн байгууллагууд эрчимтэй цахимжиж байгаатай холбоотой нэгдсэн стандартад чиглэн үйл ажиллагаа явуулж, нууцлал, аюулгүй байдал, мөнгөн дүнгийн интервал зэрэг чиглэлээр хөгжүүлэлт хийгдэж байна.</p>
<p>Голомт банк</p>	<p>ОХУ-ын эсрэг барууны орнуудын тавьсан хориг арга хэмжээ нь гүйлгээнд саад учруулж байна.</p>	<p>Корреспондент банкнуудын тоог нэмэгдүүлэх, олон төрлийн гадаад төлбөрийн системийг нэвтрүүлэх гарцыг судлах нь чухал ач холбогдолтой. Ингэснээр гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаа илүү хурдтай, найдвартай болох боломжтой. Мөн Монголбанкнаас энэ чиглэлд дэмжлэг үзүүлэх нь арилжааны банкнуудын өрсөлдөх чадварыг</p>

		нэмэгдүүлж, олон улсын санхүүгийн харилцааг өргөжүүлэхэд чухал нөлөөтэй гэж үзэж байна.
Хаан банк	<p>Саяхан болсон SIBOS олон улсын банкны хурал дээр харилцагч банкнууд хамтран ажиллахдаа тухайн улсын эдийн засгийн хүчин чадал, ашиг орлого, хууль эрх зүйн зохицуулалт, мөнгө угаах болон терроризмын эсрэг хяналтын тогтолцооны чадамжийг үнэлсэн тайлан гаргасан. Үүний дагуу Монгол Улсыг хууль тогтоомжийн хүрээнд илрүүлэлт сайн боловч хяналт шалгалтын дараах арга хэмжээ авах чадамж, комплайнсын зохицуулалт сул гэж дүгнэжээ. Энэ нь Монголын банкнуудын олон улсын хамтын ажиллагаанд саад учруулж байна. Мөн дэлхий дахинд гадаад төлбөр тооцооны ирээдүйн чиг хандлагын талаар хэлэлцэж, SWIFT сүлжээний ISO 20022 шинэчлэлтэд нийцэх, банк санхүүгийн үйлчилгээг автоматжуулж хүний</p>	<p>Сүүлийн жилүүдэд гадаад төлбөр тооцооны үйлчилгээндээ технологийн шинэчлэлүүдийг амжилттай нэвтрүүлж байна. 2023 онд SWIFT GPI системийг нэвтрүүлснээр олон улсын гүйлгээний хугацааг багасгаж, гүйлгээний явцыг бодит цаг хугацаанд хянах боломжийг бүрдүүлсэн. Энэ нь үйлчлүүлэгчдэд төлбөрийн явцыг ил тод харах боломж олгож, итгэлцлийг нэмэгдүүлсэн. Мөн VISA B2B Connect системийг ашиглан томоохон бизнесүүдэд зориулсан шуурхай төлбөр тооцоо хийх боломжийг өргөжүүлсэн нь банкны үйлчилгээг сайжруулах томоохон алхам болсон.</p> <p>Үүнээс гадна, Хаан банк Хятадын Alipay системтэй хамтран ажиллаж, өөрийн аппликейшнээр дамжуулан Хятад улс руу шууд гүйлгээ хийх боломжийг нээсэн нь гадаад төлбөр тооцооны хүртээмжийг өргөжүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна. Цаашид</p>

	<p>оролцоог багасгах нь гол зорилт болж буйг онцолсон.</p>	<p>технологийн дэвшлийг ашиглан гадаад төлбөр тооцооны аюулгүй, шуурхай байдлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ олон улсын стандартад нийцэхэд анхаарч ажиллах шаардлагатай.</p>
<p>Төрийн банк</p>	<p>Төрийн банк нь анх төрийн санхүүжилтээр байгуулагдсан тул иргэдийн халамж, дотоодын төлбөр тооцооны үйлчилгээнд түлхүү анхаарч ирсэн нь гадаад төлбөр тооцооны хөгжлийг хязгаарлаж иржээ. Хэдийгээр банк гадаад төлбөр тооцоог гүйцэтгэдэг боловч дэвшилтэт системүүдийг нэвтрүүлэхэд шимтгэл, зардал өндөр, гүйлгээний хэмжээ бага зэрэг шалтгаануудаас үүдэн эрсдэлтэйд тооцогдож байна. Энэ байдал нь цаашдын үйл ажиллагаанд хүндрэл учруулж, системийг сайжруулахад нэмэлт дэмжлэг, санхүүжилт шаардлагатай болж байна.</p>	<p>Төрийн банк нь SWIFT сүлжээг ашиглан олон улсын төлбөр тооцооны үйлчилгээгээ сайжруулахад анхаарч, 2022 оноос дотоодын банкны системтэй илүү анхаарч ажиллаж байна. Мөн SWIFT GPI системийг нэвтрүүлснээр гүйлгээний явцыг бодит цаг хугацаанд хянах боломжтой болж, хэрэглэгчдэд илүү хурдан, ил тод үйлчилгээ үзүүлэх боломж бүрдүүлсэн. Western Union-ийн хүрээнд мөнгөн шилжүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлж, гадаадад ажиллаж буй монголчуудын төлбөр, шилжүүлгийг найдвартай хүргэхэд анхаарч байна. Монгол Улсын гадаад төлбөр тооцоо нь Монголбанкны зохицуулалт, арилжааны банкнуудын ашиглаж буй системүүдээр хангагдаж байгаа хэдий ч CLS, блокчэйн зэрэг шинэ технологиудыг нэвтрүүлснээр төлбөр тооцооны хурд, найдвартай байдлыг</p>

		<p>нэмэгдүүлэх боломжтой. Монголбанк болон арилжааны банкнуудын хамтын ажиллагаа нь гадаад төлбөр тооцооны дэд бүтцийг сайжруулах, олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжихэд чухал ач холбогдолтой юм.</p>
Хас банк	<p>Монгол Улс саарал жагсаалтад байх хугацаанд Хас банкны олон улсын настро болон клирингийн данснууд хаагдсан нь банкны гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаанд томоохон хүндрэл үүсгэсэн. Үүний улмаас Америк, Европын холбоо зэрэг нөлөө бүхий бүс нутгуудад банкны данс байхгүй болсон. Мөн ОХУ-ын дайнаас үүдэн авсан хориг арга хэмжээний улмаас ОХУ руу хийх гүйлгээнд саад учирсаар байна.</p>	<p>Хас банк 2025 он гэхэд Visa B2B системийг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Энэ нь олон улсын төлбөр тооцооны аюулгүй байдал, хурд, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал алхам болох юм. Банкны зүгээс олон төрлийн бүтээгдэхүүн, гарцыг нэвтрүүлснээр иргэд болон байгууллагуудад түргэн шуурхай, найдвартай төлбөр тооцооны боломжийг хангах зорилготой.</p> <p>Хас банкны зүгээс Хятад руу төлбөр тооцооны ихэнх хувь явж буй өнөөгийн нөхцөл байдалд үндэслэн CIPS системийг нэвтрүүлэх нь боломжит шийдэл гэж үзэж байна. Энэ нь Хятад улстай хийгдэх гүйлгээнд үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах чухал алхам болно.</p>
	<p>Тээвэр хөгжлийн банк ОХУ руу хийх төлбөр тооцооны үйл явцад хяналт шалгалттай тулгарч, процесс</p>	<p>Тээвэр хөгжлийн банк корреспондент банкнуудынхаа тоог нэмэгдүүлж, АНУ-ын Нью-Йорк дахь The Bank of New York</p>

Тээвэр хөгжлийн банк	удаашралтай байгаа ч рублийн гүйлгээг зогсоолгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байна. Энэ нь банкны төлбөр тооцооны урсгалыг хэвийн явуулахад тодорхой хэмжээгээр саад учруулж байна.	Mellon зэрэг банкнуудад ам.долларын данс нээхээр төлөвлөж байна. Мөн 2025 онд Хятад улсын CIPS системийг нэвтрүүлэхээр зорьж, техник технологийн судалгааг бүрэн дуусгасан байна. Энэ системийг нэвтрүүлснээр Хятад улс руу хийгдэх гүйлгээний зардал буурах төдийгүй олон төрлийн гадаад төлбөр тооцооны гарцыг бүрдүүлж, төлбөр тооцооны саадгүй, үр ашигтай байдал хангагдах боломжтой гэж үзэж байна.
Чингис хаан банк	Чингис хаан банк нь ОХУ-д корреспондент банкны харилцаагүй болсноор гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаа бараг зогсонги байдалд орсон. Банкны үүсгэн байгуулагч нь ОХУ-ын хөрөнгө оруулагч байсан тул тус улсын санхүүгийн системтэй ойр байж ирсэн нь өнөөгийн нөхцөл байдалд томоохон бэрхшээл болж байна. Мөн Монгол Улсын арилжааны банкнууд гуравдагч хөршийн санхүүгийн системд хэт их хамааралтай байгаа нь хөрш орнуудтайгаа гүйлгээ хийх	Сайжруулахын тулд жижиг банкнуудыг тодорхой валютууд дээр төвлөрүүлэн хуваарилж, хурдан, найдвартай гүйлгээ хийх боломжтой болохыг судлах нь зүйтэй. Томоохон банкнууд ам.доллар, евро зэрэг голлох валютууд дээр төвлөрч, жижиг банкнууд бусад валютуудын гүйлгээг хариуцсанаар төлбөр тооцооны хурдац нэмэгдэж, эрсдэл буурах боломжтой. Монголбанк энэ хуваарилалтыг хянаж, удирдсанаар гадаад төлбөр тооцооны уялдаа сайжирч, тогтвортой байдлыг хангах нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

	<p>боломжийг хязгаарлаж буй шалтгаануудын нэг болж байна.</p>	
Капитрон банк	<p>Капитрон банкны гадаад төлбөр тооцоо нь Монгол Улс саарал жагсаалтад ороод удаагүй байгаа учир өндөр шалгалт, хяналтын дор явагдаж байна. 10 дугаар сараас хойш ОХУ руу ямар ч гүйлгээ хийхгүй байгаа бөгөөд энэ нь ОХУ-ын эсрэг тавигдсан хориг арга хэмжээтэй холбоотой. SWIFT системийг ашиглах үед хэрэглэгчид замын банк болон хүлээн авагч банкны шимтгэлийг зөв ойлгоогүйгээс үүдэн гүйлгээ саатах тохиолдол гардаг. Мөн гүйлгээ олон банкаар дамжин, хэр удах нь тодорхойгүй асуудал үүсэж, гадаад төлбөр тооцоо удааширч байна.</p>	<p>Капитрон банк одоогоор шинэ системүүдийг судалж, олон төлбөрийн гарц нэвтрүүлэх замаар гадаад төлбөр тооцооны хурд, хүртээмжийг сайжруулахыг зорьж байна. SWIFT GPI системийг бүрэн нэвтрүүлээгүй байгаа ч нэвтрүүлэх явц дундаа яваа нь ирээдүйд гүйлгээний хугацаа болон ил тод байдлыг сайжруулах хүлээлтийг бий болгож байна. Цаашид олон төрлийн гадаад төлбөрийн системийг нэвтрүүлснээр банкны үйл ажиллагааг илүү үр ашигтай болгох боломжтой.</p>
Богд банк	<p>Богд банкны гадаад төлбөр тооцоонд тулгарч буй гол саад бэрхшээл нь олон улсын хүрээнд дансны хүртээмж хангалтгүй байдал юм. Тус банк нь ам.доллар болон еврогийн</p>	<p>Богд банк олон корреспондент банктай харилцаа тогтоож, олон улсын банкнуудад дансаа нэмэгдүүлэх нь тулгарч буй асуудлыг шийдвэрлэх нэг гарц юм. Мөн тус банк SWIFT GPI системийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлээд байгаа бөгөөд энэ нь</p>

	<p>данс нээхэд хүндрэлтэй тулгарч, шилжүүлэг хийх явцад олон улс дамжин, олон шатлалаар явагддаг нь үйл явцыг удаашруулдаг. Мөн улс хоорондын цагийн зөрүүгээс шалтгаалж гүйлгээ хойшлогдох тохиолдол элбэг гарч байна.</p>	<p>гүйлгээний хугацааг богиносгож, үйл явцыг ил тод болгох ирээдүйтэй шийдэл болж байна.</p>
Ариг банк	<p>Ариг банкны гадаад төлбөр тооцоонд тулгарч буй гол саад нь ОХУ дахь корреспондент банкнуудтай холбоотой юм. Дайны нөхцөл байдлаас үүдэн зөвхөн нэг банк Рублийн гүйлгээ хийх зөвшөөрөлтэй ажиллаж байгаа бөгөөд зөвхөн эм, хүнс, түлш гэсэн гурван төрлийн гүйлгээ хийгдэж байна. Энэ нь бусад төрлийн гүйлгээг хязгаарлах гол шалтгаан болж байна. Мөн долларын корреспондент банк байхгүй болсноор долларын гүйлгээ бүрэн зогсоод байна.</p>	<p>Ариг банк өөр төлбөрийн сүлжээ судалж, нэвтрүүлэх замаар гадаад төлбөр тооцооны цар хүрээг өргөжүүлэх боломжтой гэж үзэж байна. Тус банк SWIFT GPI системийг нэвтрүүлсэн хэдий ч хэрэглэгчдийн идэвх бага байгаа тул илүү үр ашигтай ашиглахад анхаарах шаардлагатай. Мөн 2025 онд VISA B2B системийг хэрэгжүүлснээр илүү шуурхай, найдвартай гүйлгээ хийх боломж бүрдэнэ гэж төлөвлөж байна</p>

Монголын арилжааны банкнуудын гадаад төлбөр тооцооны өнөөгийн байдалд тулгарч буй бэрхшээлүүд нь банк бүрийн онцлогоос хамааран харилцан адилгүй байгаа ч нийтлэг асуудлууд анзаарагдаж байна. Гадаад төлбөр тооцооны үйлчилгээнд хориг

арга хэмжээ, корреспондент банкны хязгаарлалт, гүйлгээний шимтгэл өндөр, саарал жагсаалтад орох үеийн хүндрэл зэрэг хүчин зүйлс хамгийн их нөлөөлж байна. Тухайлбал, Хас банк саарал жагсаалтын үед олон улсын данснууд хаагдаж, Европ болон Америкийн банкнуудтай харилцаагаа алдсан бол Голомт банк ОХУ-тай холбоотой гүйлгээний хүндрэлээс шалтгаалан нийгмийн хариуцлагын хүрээнд гүйлгээг үргэлжлүүлэн хийж байгаа тухай дурдсан. Мөн Худалдаа хөгжлийн банк SWIFT GPI болон The Bank of New York Mellon-тай хамтран гүйлгээний хурд, тогтвортой байдлыг нэмэгдүүлэх шинэчлэлүүдийг хэрэгжүүлж байгаа бол Хаан банк олон улсын түвшний технологиудыг ашиглан гүйлгээний ил тод байдлыг нэмэгдүүлэх, аюулгүй байдлыг хангахад анхаарч байна. Харин Тээвэр хөгжлийн банк CIPS системийг нэвтрүүлэх боломжийг судалж байгаа бол Чингис хаан болон Ариг банкнууд ОХУ-д төвлөрсөн корреспондент банкны сүлжээ нь хязгаарлагдмал байгаагаас гадаад гүйлгээнд хүндрэлтэй тулгарч байна. Төрийн банк, Капитрон банк, Богд банк олон улсын корреспондент банкны тоог нэмэгдүүлэх, технологийн дэвшлийг нэвтрүүлэх шаардлагатай байна. Эдгээр асуудлуудыг шийдвэрлэхийн тулд дэвшилтэт системүүдийг нэвтрүүлэх, олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай харилцаагаа өргөжүүлэх, зохицуулалтын орчныг сайжруулах зэрэг арга хэмжээ авах шаардлагатай байгаа нь энэхүү судалгаагаар тодорхой болж байна.

4.3 Олон улсын кейс харьцуулсан SWOT шинжилгээ

Давуу тал

Хөрш орнуудтай харилцаа сайжруулах боломж: Казахстан болон Хятад улсын CIPS систем нь хөрш орнуудтай шууд төлбөр тооцоо хийх боломжийг нэмэгдүүлсэн. Монгол Улс эдгээр системийг нэвтрүүлснээр Хятадтай хийх худалдааны зардлыг бууруулах, гүйлгээний хурдыг нэмэгдүүлэх боломжтой.

Гадаад төлбөр тооцооны системд шинэ гарц нээх: АНУ-ын CHIPS болон FedNow системийн үр ашиг, найдвартай байдлыг Монгол Улсад хэрэгжүүлснээр олон улсын төлбөр тооцооны сүлжээнд өргөн хүрээтэй нэгдэх боломж бүрдэнэ.

Сул тал

Санхүүгийн нөөцийн хомсдол: Олон улсын дэвшилтэт системийг нэвтрүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт, дэд бүтцийн зардал өндөр. Монгол Улсын банкнууд эдгээрийг дангаараа санхүүжүүлэхэд хүндрэлтэй.

Технологийн бэлтгэл дутмаг: Олон улсын стандарт шаардлагыг хангах технологийн чадамж хангалтгүй. Мөн хүний нөөцийн ур чадвар дутагдаж байна.

Геополитикийн нөлөөлөл: ОХУ-ын хориг арга хэмжээ, бүс нутгийн улс төрийн тогтворгүй байдал Монгол Улсын гадаад төлбөр тооцооны урсгалд сөрөг нөлөө үзүүлж байна.

Боломж

Бүс нутгийн системд интеграци хийх: Казахстан болон Хятад улсын жишгийг даган CIPS зэрэг системийг нэвтрүүлснээр Монголын гадаад төлбөр тооцооны бие даасан байдал нэмэгдэж, худалдааны хамаарлыг бууруулах боломжтой.

Дижитал шилжилт хийх: Банк, финтекийн хамтын ажиллагааг өргөжүүлснээр цахим төлбөр тооцоо, мобайл суурилсан системүүдийг хөгжүүлэх боломжтой.

Аюул

Хөрөнгө оруулалтын эрсдэл: Шинэ технологи нэвтрүүлэхэд шаардагдах их хэмжээний зардал нь эдийн засгийн дарамт болж болзошгүй.

Эрх зүйн зохицуулалтын дутагдал: Шинэ системүүдийг нэвтрүүлэхэд шаардлагатай хууль, эрх зүйн орчин дутмаг.

Системийн аюулгүй байдлын эрсдэл: Кибер аюул занал, мэдээллийн хамгаалалтад сул тал гарвал хэрэглэгчдийн итгэл алдагдах эрсдэлтэй.

Бүлгийн дүгнэлт

Арилжааны банкнуудын гадаад төлбөр тооцооны өнөөгийн байдалд тулгарч буй бэрхшээлүүд нь нийтлэг болон тухайн банкны онцлог шинжүүдээс хамаарч харилцан адилгүй байна. Нийтлэг тулгамдаж буй асуудлуудад хориг арга хэмжээ, корреспондент банкны хязгаарлагдмал байдал, гүйлгээний шимтгэлийн өндөр түвшин, саарал жагсаалтад орох үеийн хүндрэлүүд багтаж байна. Тухайлбал, Хас банк саарал жагсаалтын үеэр олон улсын данс хаагдсан, Голомт банк ОХУ-тай холбоотой гүйлгээний хүндрэлээс үүдэн эрсдэлтэй ч нийгмийн хариуцлагын хүрээнд гүйлгээгээ үргэлжлүүлж байна. Худалдаа хөгжлийн банк SWIFT GPI болон The Bank of New York Mellon-тай хамтран гүйлгээний хурд, тогтвортой байдлыг нэмэгдүүлэх шинэчлэл хийж байгаа бол Хаан банк олон улсын жишиг технологийг ашиглан гүйлгээний ил тод байдлыг нэмэгдүүлэхэд анхаарч байна. Тээвэр хөгжлийн банк CIPS системийг нэвтрүүлэх судалгаа хийж, Чингис хаан болон Ариг банк ОХУ-д төвлөрсөн корреспондент банкны хязгаарлалтаас үүдэн хүндрэлтэй тулгарч байгаа бол Төрийн банк, Капитрон банк, Богд банк зэрэг банкнууд олон улсын корреспондент банкны сүлжээг өргөжүүлэх, технологийн дэвшлийг нэвтрүүлэх шаардлагатай байна.

Эдгээр асуудлуудыг шийдвэрлэхийн тулд Монгол Улсын арилжааны банкнууд олон улсын жишигт нийцсэн шинэчлэлүүдийг нэвтрүүлж, дэвшилтэт технологиудыг ашиглах, олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх шаардлагатай байна. Судалгаанд хамрагдсан мэргэжилтнүүдийн дүгнэлтээс харахад, ОХУ-тай холбоотой гүйлгээний саатал, Монголбанкны бодлогын гэнэтийн өөрчлөлтүүд, олон улсын комплайнсын шаардлагууд зэрэг нь арилжааны банкнуудын үйл ажиллагаанд саад учруулж байна. Банкны салбарын өрсөлдөх чадварыг сайжруулахын тулд шинэчлэл хийх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

ДҮГНЭЛТ

Монгол улсын арилжааны банкнууд SWIFT, Western Union, Moneygram, P2P, Корреспондент банк зэрэг төлбөрийн хэрэгслүүдийг өргөн ашиглан дэлхийн эдийн засгийн интеграцид гол үүрэг гүйцэтгэж, олон улсын санхүүгийн харилцааг бэхжүүлж байна. SWIFT GPI, ISO 20022 стандарт зэрэг шинэчлэлтүүд нь төлбөр тооцооны үр ашгийг нэмэгдүүлж, ил тод, аюулгүй байдлыг хангах шинэ боломжуудыг олгодог. Мөн аккретив, инкасс зэрэг уламжлалт хэрэгслүүд нь итгэлцлийг нэмэгдүүлж, санхүүгийн эрсдэлийг бууруулахад үр дүнтэй байна.

Монгол Улсын арилжааны банкнууд гадаад төлбөр тооцооны үйлчилгээгээ сайжруулж, олон улсын түвшинд хүрэх зорилготой ажиллаж байгаа ч эрх зүйн зохицуулалт, технологийн шинэчлэлийн хүрээнд тодорхой хүндрэлүүдтэй тулгарсаар байна. Тухайлбал, корреспондент банкны хязгаарлагдмал байдал, гүйлгээний шимтгэлийн өндөр түвшин, саарал жагсаалтад орсон үеийн хүндрэл зэрэг нь банкнуудын гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Томоохон банкнууд болох Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Хаан банк зэрэг нь SWIFT GPI системийг амжилттай нэвтрүүлснээр гүйлгээний хурд болон харилцагчдын итгэлцлийг нэмэгдүүлж байгаа ч зарим банкууд уг системийг бүрэн нэвтрүүлэх шаардлагатай хэвээр байна.

Дэлхийн жишиг туршлагыг судалбал, Казахстан улс Хятадын CIPS системд холбогдож, төлбөр тооцооны хараат байдлаа багасгах чиглэлээр амжилттай ажиллаж байна. Сингапур улс дижитал технологийг амжилттай нэвтрүүлж, PayNow, SGQR зэрэг системээр төлбөр тооцооны хүртээмж, хурдыг нэмэгдүүлсэн бол Хятад улс CIPS системийг ашиглан аюулгүй, шуурхай гүйлгээг ханган ажиллаж байна. Европын Холбоо SEPA, TARGET2, TIPS зэрэг системүүдээр эдийн засгийн интеграция өргөжүүлж, АНУ-ын Fedwire, CHIPS зэрэг системүүд олон улсын гүйлгээг бодит цагийн горимд найдвартай боловсруулж байгаа нь Монгол Улсад хэрэгжүүлж болохуйц туршлагууд юм. Судалгаанаас харахад улс орнууд эхлээд стратегийн ач холбогдолтой хөрш орнуудтайгаа төлбөр тооцооны асуудлаа шийдвэрлэж, бүс нутгийн интеграцийг нэмэгдүүлдэг байна. Энэ нь олон улсын түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх суурь болж өгдөг. Монгол Улс энэхүү туршлагыг өөрийн нөхцөлд нийцүүлэн ОХУ, БНХАУ зэрэг хөрш орнуудтайгаа төлбөр тооцооны системээ сайжруулж, дараа нь олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх шаардлагатай байна.

Эдгээр туршлагыг Монголын нөхцөлд нийцүүлэн хэрэгжүүлснээр жижиг банкнуудын өрсөлдөх чадвар сайжирч, төлбөр тооцооны тогтвортой байдал хангагдаж, олон улсын санхүүгийн системд амжилттай оролцох боломжтой. Монгол Улс гадаад

төлбөр тооцооны системээ шинэчлэх, дижитал технологийг түлхүү нэвтрүүлэх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай бөгөөд энэ нь эдийн засгийн тогтвортой хөгжилд чухал хувь нэмэр оруулна.

САНАЛ ЗӨВЛӨМЖ

Арилжааны жижиг банкнуудад:

1. Технологийн шинэчлэлд анхаарах:
 - SWIFT GPI, ISO 20022 стандарттай нийцсэн дотоод процессын автоматжуулалтыг хурдасгах.
 - Блокчейн, CLS зэрэг дэвшилтэт технологийг судалж, хэрэгжүүлэх замаар төлбөр тооцооны хурд, аюулгүй байдлыг сайжруулах.
2. Олон улсын харилцааг өргөжүүлэх:
 - CIPS, CHIPS зэрэг бусад төлбөрийн системийг нэвтрүүлэх боломжийг судлаж нэвтрүүлэх.
 - Европын Холбоо, Сингапур зэрэг орнуудын туршлагыг ашиглан нэгдсэн стандарттай, аюулгүй төлбөр тооцооны платформуудыг судлах.
3. Комплайнсын шаардлагыг хангах:
 - Олон улсын банкны стандарт, комплайнсын шалгуурыг байнга сайжруулж, дотоод хяналт, тайлангийн тогтолцоог илүү уялдаатай болгох.
 - Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлогыг хэрэгжүүлж, ФАТФ-ын зөвлөмжийг бүрэн хангах.
4. Хэрэглэгчийн төвтэй үйлчилгээ хөгжүүлэх:
 - Хэрэглэгчийн сургалт, мэдээлэл олгох үйлчилгээг өргөжүүлж, цахим аюулгүй байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх.

Монголбанкинд:

1. Зохицуулалтын орчныг сайжруулах:
 - Олон улсын стандартуудтай нийцсэн, урт хугацааны тогтвортой бодлого боловсруулах. Банк хоорондын гадаад гүйлгээтэй холбоотой шаардлагуудыг уялдуулах замаар арилжааны банкнуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.
 - Төлбөр тооцооны системийн хяналтыг сайжруулж, зөвшөөрөл олгох журмыг илүү уян хатан болгох.

2. Бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх:

- Казахстан, Сингапур, Европын Холбоо, Хятад зэрэг орнуудын дэвшилтэт төлбөрийн системүүдтэй хамтран ажиллах, туршлагыг нутагшуулах.
- CIPS зэрэг бие даасан төлбөрийн системүүдтэй холбогдох боломжийг судалж, Монгол Улсын гадаад төлбөр тооцооны хараат бус байдлыг нэмэгдүүлэх.

3. Технологийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих:

- Банкны дотоод болон гадаад процессын автоматжуулалтыг дэмжихэд зориулж санхүүжилтийн болон техникийн зөвлөгөө үзүүлэх.
- Блокчейн, хиймэл оюун ухаан зэрэг дэвшилтэт технологийг нэвтрүүлэх бодлого боловсруулж, арилжааны банкнуудтай хамтран хэрэгжүүлэх.

Судлаачийн хувьд:

Энэхүү судалгаа нь цаашид арилжааны банкуудын гадаад төлбөр тооцооны технологийн дэвшлүүд хэрхэн нөлөөлж буйг тодорхойлоход чухал суурь мэдээлэл болж байна. Цаашид дараах чиглэлээр үр ашгийн судалгаа хийх боломжтой

- SWIFT GPI системийн бүх банканд нэвтэрснээр үүсэж буй үр дүнг тооцоолох.
- CIPS, CHIPS зэрэг төлбөрийн систем нь олон улсын гүйлгээг хялбаршуулж, гадаад худалдааны үйл ажиллагааны хурд, зардалд үзүүлэх нөлөөг шинжлэх.
- CIPS, CHIPS төлбөрийн систем нь хэрэглэгчдийн санхүүгийн үйлчилгээний хүртээмж, найдвартай байдлыг нэмэгдүүлэхэд хэрхэн нөлөөлж буйг судлах.

НОМЗҮЙ

Монгол хэл дээрх

1. Б.Санжмятав. (2013). *Олон улсын худалдаа* Улаанбаатар
2. Г. Балж, Д. (2010). *Банк санхүүгийн үндэс*. Улаанбаатар
3. Н.Батнасан (2013). *Гадаад худалдаа*. Улаанбаатар
4. Д.Авирмэд (2013). *Олон улсын эдийн засгийн харилцаа*. Улаанбаатар
5. Д.Дүгэржав (1996). *Бизнесийн эрх зүй*. Уланбаатар
6. Монголбанк.(2016). *Монгол улсын үнэсний төлбөрийн систем хөгжүүлэх стратеги*.
7. Монголбанк. (2022). *Монгол-Орорсын банкуудын корреспондент харилцааг хөгжүүлэх, хил дамнасан төлбөр тооцооны системийн талаарх семинар*.
8. Монголбанк. (2022). *Олон улсын төлбөр тооцооны нөхцөл байдал*.
9. Э.Анар. (2023). *“Big Data” системийг нэвтрүүлснээр банкуудын тайлан тооцоог сайжруулна*. Itoim.mn.
10. Монголбанк. (2023). *Монголбанк Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн Төв банкнуудын Төлбөр тооцооны хорооны 29 дүгээр хуралд оролцлоо*.
11. Төлбөр тооцооны системийн хороо. (2006). *Төлбөр тооцооны системийн хороо*.
12. Н.Баяртсайхан. (2019). *Төлбөрийн систем дэлхийн шилдэг түвшинд хүрнэ*. Монголбанк.
13. Азийн хөгжлийн банк. (2023). *АХБ-ны Монгол дахь цахим худалдаа төсөл*.
14. Г.Билэгсайхан. (2024). *Монголыг дэлхийн долларын төлбөрийн системтэй эргэн холбосон анхны банк боллоо*. News.mn.
15. Азийн хөгжлийн банк. (2020). *Монгол Улсын санхүүгийн салбар дахь үйл ажиллагаа*.
16. Монголбанк. (2023). *Олон улсын хамтын ажиллагаа*.
17. Монголын Хуульчдын Холбоо. (2023). *Виртуал хөрөнгийн эрх зүйн зохицуулалт*.
18. Эдийн Засгийн Судалгаа, Эрх Зүйн Зөвлөх Үйлчилгээний Төв. (2020). *Банкуудын өрсөлдөөний тойм*.
19. Монголын Санхүүгийн Технологийн Холбоо. (2022). *Монголын төлбөр тооцооны системийн дэд бүтэц*.
20. Г.Цэвэгжав. (2023). *Цахим шилжилт амжилттай явж байна*. ХасБанк.
21. Гадаад Харилцааны Яам. (2023). *Монгол Улс, Евразийн Эдийн засгийн холбооны хоорондын хамтын ажиллагаа*.
22. Монголбанк. (2023). *Монголбанкны 2023 оны онцлох үйл явдлын товчоон*.
23. Голомт банк. (2023). *Гадаад төлбөр тооцооны үйлчилгээний тайлан*.

24. Хаан банк. (2023). *SWIFT GPI систем болон гадаад төлбөр тооцооны тайлан*.
25. Худалдаа хөгжлийн банк. (2023). *Гадаад худалдааны санхүүжилт ба төлбөрийн системийн танилцуулга*.
26. Төрийн банк. (2023). *Олон улсын төлбөр тооцооны дэд бүтэц ба SWIFT системийн хэрэглээ*.
27. Үндэсний Статистикийн Хороо. (2023). *Гадаад худалдааны тайлан*.
28. Үндэсний Статистикийн Хороо. (2023). *Монгол Улсын банкны гадаад актив, пассивын тэнцэл*.

Гадаад хэл дээрх

1. Asian Development Bank (ADB). (2023). *Digital Finance in Asia: Trends and Opportunities*. Retrieved from adb.org
2. Bank for International Settlements (BIS). (2023). *ISO 20022 Implementation Overview*. Retrieved from bis.org
3. Central Bank of Singapore (MAS). (2023). *PayNow and SGQR: Advancing Seamless Payments*. Retrieved from mas.gov.sg
4. European Central Bank (ECB). (2023). *TARGET2 and SEPA: Europe's Payment Infrastructure*. Retrieved from ecb.europa.eu
5. European Payment Council (EPC). (2023). *SEPA Instant Credit Transfer Scheme*. Retrieved from epc-cep.eu
6. Financial Action Task Force (FATF). (2023). *AML and CFT Compliance Standards*. Retrieved from fatf-gafi.org
7. International Monetary Fund (IMF). (2022). *The Role of Digital Payments in Global Finance*. Retrieved from imf.org
8. Mastercard. (2023). *Digital Payments Landscape*. Retrieved from mastercard.com
9. Monetary Authority of Singapore (MAS). (2023). *Digital Transformation in Payments*. Retrieved from mas.gov.sg
10. People's Bank of China (PBOC). (2023). *Cross-Border Interbank Payment System (CIPS) Overview*. Retrieved from pbc.gov.cn
11. Stripe. (2023). *Global E-Commerce Payment Solutions*. Retrieved from stripe.com
12. SWIFT. (2023). *GPI: Transforming Cross-Border Payments*. Retrieved from swift.com
13. Tencent. (2023). *WeChat Pay Global Expansion Strategy*. Retrieved from wechat.com
14. Visa. (2023). *Advancing Global E-Payment Ecosystems*. Retrieved from visa.com
15. World Bank. (2023). *Cross-Border Payments and Financial Inclusion*. Retrieved from worldbank.org

16. World Economic Forum (WEF). (2023). *The Future of Payments and Financial Systems*.

Retrieved from [weforum.org](https://www.weforum.org)

ХАВСРАЛТ

Хавсралт А Судалгааны асуулга

СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮН

Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын арилжааны банкны гадаад төлбөр тооцооны системийг сайжруулах, инновацилаг шийдлээр хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг тодорхойлох юм.

Судалгаанд Хаан банк, Худалдаа хөгжил, Голомт банк, Төрийн банкны гадаад төлбөр тооцооны газар, нэгж, хэлтэсд ажилдаг нийт 63 ажилтнаас анкетийн аргаар судалгааг авсан.

Ерөнхий асуултын дүн:

1. Та аль банкинд ажилладаг вэ?
 - А. Хаан банк- 21
 - В. Худалдаа хөгжил- 15
 - С. Голомт банк- 11
 - Д. Төрийн банк- 16
2. Таны ажилласан жил:
 - А. 5 жил-36
 - В. 5-10 жил-15
 - С. 11-15 жил-0
 - Д. 15-аас дээш жил-12
3. Таны албан тушаал:
 - А. Теллер-10
 - В. Аудитор-6
 - С. Төлбөр тооцооны мэргэжилтэн-42
 - Д. Нягтлан-2
 - Е. Хэлтсийн захирал-4
 - Ф. Захирал-1
4. Таны нас:
 - А. 22-25 нас- 3
 - В. 26-30 нас-6
 - С. 31-35 нас-24
 - Д. 36-аас дээш-30

Үндсэн асуултын дүн:

1. Танай банк аль чиглэлээр гадаад төлбөр тооцооны үйлчилгээг эрхэлдэг вэ?

- A. Байгууллага
 - B. Иргэд
 - C. Байгууллага иргэд-63
2. Танай банкинд эдгээрээс гадаад төлбөр тооцоотой холбоотой ямар асуудлууд байгаа вэ?
- A. ОХУ (Геополитикийн асуудал)-17
 - B. Гүйлгээ саатах-13
 - C. Комплейнсийн асуудал-7
 - D. Гадаадруу нүйлгээ хийх хэрэглэгчдийн тоо бусад банкуудтай харьцуулахад бага-6
 - E. Хэрэглэгчдэд тохирсон гадаад төлбөр тооцооны хэрэгсэл цөөн-4
 - F. Шимтгэл өндрөөс болоод хэрэглэгчид гүйлгээ хийх нь бага-0
 - G. Валютын ханшийн эрсдэл-2
 - H. Монголбанкны гэнэтийн бодлого шийдвэр гаргалт-14
3. Олон улсын карттай холбоотой ямар асуудлууд гарч байсан бэ?
- A. Хэрэглэгч картын нууцлалаа алдснаас гарсан асуудлууд-10
 - B. Картын брендээс хамаарч олон улсад пос машин уншихгүй байх тохиолдолд ирсэн гомдол-19
 - C. Аюулгүй байдлын үүднээс давхар баталгаажуулалт хийхэд хэрэглэгч анзаарахгүй өнгөрөх-25
 - D. Хэрэглэгч залиланд өртөөд гомдол гаргах9
4. Карттай холботой гарсан асуудлууд дээр ямар арга хэмжээ авдаг вэ?
.....
5. SWIFT гүйлгээтэй холбоотой ямар асуудлууд гарч байсан бэ?
- A. Хэрэглэгч мэдээллээ дутуу өгөх юм уу буруу зөрүүтэй өгөх-20
 - B. Гүйлгээ саатах-33
 - C. SWIFT-ээс хараат байдал өндөр-10
6. SWIFT-тэй холбоотой гүйлгээнд гарсан асуудалд банкны зүгээс болон Монголбанкны зүгээс ямар арга хэмжээ авдаг вэ?
.....
7. Гадаад төлбөр тооцоон дээр цаашип сайжруулах санал зөвлөмж (бүтээгдэхүүн үйлчилгээ гэх мэт)
.....

Хавсралт В Арилжааны банкуудын корреспондент банкны харилцаа болон гадаад гуйвуулга хийх боломжтой валют

Арилжааны банк	Корреспондент банк	Валют
Хаан банк	INDUSTRIAL COMMERCIAL BANK OF CHINA BANK OF CHINA (ERLIANHAOTE) BANK OF INNER MONGOLIA THE BNY MELLON BANK ODDO BHF GERMANY DBS BANK BANK SINGAPORE OCBC BANK SINGAPORE KOOKMIN BANK SOUTH KOREA KEB HANA BANK SOUTH KOREA INDUSTRIAL BANK OF KOREA SHINSHAN BANK WOORI BANK COMMERZBANK AG GERMANY CAIXA BANK S.A SPAIN AGRICULTURAL BANK OF CHINA BANK OF CHINA BEIJING BANK OF CHINA HONG KONG CHINA CONSTRUCTION BANK SUMITOMO MITSUI BANKING CORPORATION JAPAN MITSUBUSHI UFJ FINANCIAL GROUP JAPAN MIZUHO BANK JAPAN ANZ BANK AUSTRALIA	USD, EUR, CNY, JPY, CHF, GBP, CAD, AUD, KRW, SGD, NZD, HKD
Худалдаа хөгжлийн банк	THE BANK OF NEW YORK MELLON NATIXIS FRANCE KEB HANA BANK SOUTH KOREA KOOKMIN BANK SHINSHAN BANK	USD, CNY, EUR, GBP, JPY, KRW, AUD, CAD, CHF, RUB, NZD, HKD, SGD, SEK, TRY, THB, INR, CZK, DKK, DZD, HUF, ILS, ISK, KWD,

	<p>WOORI BANK INDUSTRIAL AND COMMERCIAL BANK OF CHINA BANK OF CHINA LIMITED HONG HONG BANK OF INNER MONGOLIA OCBC BANK SINGAPORE DBS BANK LIMITED SINGAPORE COMMERZBANK AG GERMANY KASIKORNBANK PUBLIC COMPANY LIMITED THAILAND</p>	<p>MXN, NOK, PLN, RON, SAR, TND, ZAR</p>
Голомт банк	<p>BANK OF NEW YORK MELLON KOOKMIN BANK SOUTH KOREA OCBC BANK SINGAPORE KEB HANA BANK KOREA SHINSHAN BANK KOREA BANK OF CHINA ERLIAN MENGSANG BANK CHINA BAOTOU ICBC BANK CHINA HUHHOT BANK OF INNER MONGOLIA BERLINER SPARKASSE GERMANY ODDO BHF GERMANY BANK OF CHINA HONG KONG DBS BANK SINGAPORE CROWN AGENTS BANK UNITED KINGDOM</p>	<p>USD, CNY, EUR, JPY, KRW, RUB, GBP, CHF, AUD, CAD, SGD, HKD, PLN, TRY</p>
Хас банк	<p>OVERSEA-CHINESE BANKING SINGAPORE CORPORATION LTD SINGAPORE KB KOOKMIN BANK SOUTH KOREA ODDO BHF SE GERMANY NATIONAL BANK OF CANADA</p>	<p>USD, EUR, CNY, JPY, CAD, AUD, KRW, SGD, HKD</p>

	<p>KEB HANA BANK SOUTH KOREA INDUSTRIAL AND COMMERCIAL BANK OF CHINA BANK OF INNER MONGOLIA MENGSANG BANK LTD CHINA AGRICULTURAL BANK OF CHINA BANK OF CHINA ERLIAN BANK OF CHINA HONG KONG SUMITOMO MITSUI BANKING CORPORATION JAPAN MUFG BANK LTD JAPAN COMMERZBANK AG GERMANY AUSTRALIAN AND NEW ZEALAND BANKING GROUP LIMITED AUSTRALIA</p>	
Төрийн банк	<p>AGRICULTURAL BANK OF CHINA INDUSTRIAL AND COMMERCIAL BANK OF CHINA LIMITED CHINA CONSTRUCTION BANK CORPORATION BANK OF CHINA WOORI BANK KOOKMIN BANK KEB HANA BANK UNICREDIT BANK SUMITOMO MITSUI MUFG BANK OVERSEA-CHINESE BANKING CORPORATION</p>	USD, CNY, KRW, EUR, JPY, GBP, SGD, AUD
Богд банк	<p>KB KOOKMIN BANK, SOUTH KOREA BANK OF INNER MONGOLIA, PRC</p>	USD, CNY, EUR, KRW, HKD

	MENGSHANG BANK, BAOTOU, PRC AGRICULTURAL BANK OF CHINA, PRC SHANGHAI PUDONG DEVELOPMENT BANK CO., LTD, PRC	
Тээвэр хөгжлийн банк	ALFA BANK, RUSSIA CCB, CHINA KEB, HANA BANK, SOUTH KOREA COMMERZBANK AG, GERMANY BAYERISCHE LANDESBANK, GERMANY SMBC, JAPAN OCBC, SINGAPORE	USD, EUR, JPY, KRW, GBP, HKD, CHF, SGD, TRY,
Капитрон банк	AGRICULTURAL BANK OF CHINA ANTIF YATIRIM BANKASI A.S BANK OF CHINA BANK OF INNER MONGOLIA BANQUE DELUBAC ZHEJIANG CHOUZHOU COMMERCIAL BANK CREDIT BANK OF MOSKOW DBS BANK INDUSTRIAL AND COMMERCIAL BANK OF CHINA IBEC (INTERNATIONAL BANK FOR ECONOMIC COOPERATION) KOOKMIN BANK MENGSHANG BANK SBERBANK SUMITOMO MITUI BANKING CORP TRANSKAPITAL BANK UNICREDIT BANK	USD, EUR, JPY, CNY, RUB, KRW, TRY, SGD
Ариг банк	CHINA CONSTRUCTION BANK ACRICULTURAL BANK OF CHINA ZHEJIANG CHOUZHOU	USD, EUR, CNY, RUB

	COMMERCIAL BANK BANK OF INNER MONGOLIA BAYERISCHE LANDESBANK INTERNATIONAL BANK FOR ECONOMIC CO- OPERATION TRANSKAPITAL BANK CREDIT BANK OF MOSKOW	
--	--	--

Хавсралт С SWIFT-ээр дамжуулан төлбөр тооцоо хийх үе шат

Гүйлгээний мэдээллийг бэлтгэх	Төлбөрийн үүсгэгч буюу хүлээн авагч нь өөрийн банк дээрээ гүйлгээний хүсэлт гаргана. Энэхүү хүсэлтэд хүлээн авагчийн банкны SWIFT код, дансны дугаар, төлбөрийн дүн, валютын төрөл зэрэг мэдээллүүдийг оруулна. Мөн SWIFT систем нь стандарчилсан MT (Message Type) форматыг ашигладаг бөгөөд гүйлгээний төрөл бүрт өөр өөр MT формат ашиглана. Жишээ нь: Олон улсын мөнгөн шилжүүлэгт MT103-г, валютын арилжаанд MT202-г хэрэглэнэ.
Гүйлгээний баталгаажуулалт ба аюулгүй байдал	SWIFT сүлжээгээр дамжин бүх гүйлгээ нь SWIFT Secure IP Network (SIPN)-ээр дамждаг. Энэхүү сүлжээ нь гүйлгээг шифрлэн илгээж, банкны мэдээллийг хамгаалдаг. Гүйлгээг илгээхээс өмнө гүйлгээний бүрэн бүтэн байдал, SWIFT кодын үнэн зөв байдлыг шалгах автомат хяналтын систем ажилладаг.
SWIFT сүлжээгээр мэдээлэл дамжуулах	Гүйлгээг илгээж буй банк нь SWIFT сүлжээг ашиглан мэдээллээ хүлээн авагчийн банк руу дамжуулдаг. SWIFT сүлжээ нь олон улсын серверээр дамжин мэдээллийг хүргэдэг бөгөөд гүйлгээг стандартчилагдсан MT форматаар илгээнэ. SWIFT нь өгөгдлийг шифрлэж дамжуулдаг тул мэдээлэл нууцлалтай хадгалагдана. Дамжуулах явцад мэдээлэл өөрчлөгдөхөөс сэргийлсэн хяналтын системтэй.
Корреспондент банкуудын оролцоо	Хэрэв гүйлгээний банк болон хүлээн авагчийн банк шууд холбоогүй бол гүйлгээ корреспондент банк буюу зуучлагчаар дамждаг. Корреспондент банк нь хоёр талын дунд зуучлан, гүйлгээг дамжуулж өгдөг. Энэ үед банк хоорондын төлбөрийн шимтгэл нэмэгдэх боломжтой бөгөөд гүйлгээний зардлыг хоёр тал тохиролцож шийднэ.

<p>Гүйлээг хүлээн авагчийн банк хүлээн авах</p>	<p>Гүйлгээ хүлээн авагч банканд ирсний дараа хүлээн авагчийн дансанд хуваарилагддаг. Энэ нь SWIFT систем дээр мэдээллийн баталгаажуулалт болон дансны шалгалт хийгдсэнээр гүйцэтгэгдэнэ. Хүлээн авагч банк гүйлгээг хүлээн авсны дараа харилцагчаа төлбөрийг хүлээн авсныг мэдэгддэг. Хэрэв (GPI) ашигласан бол гүйлгээний явцыг бодит цаг хугацаанд хянах боломжтой байдаг.</p>
<p>Гүйлгээний баримт, тайланг гаргах</p>	<p>SWIFT систем нь гүйлгээний талаар тайлан гаргаж төлбөрийн бүх шат дамжлагыг архивлаж хадгалдаг. Энэ нь харилцагч болон банканд шаардлагатай тохиолдолд гүйлгээний мэдээллийг баталгаажуулах баримт болдог. SWIFT нь гүйлгээг хийгдсэн эсэхийг хоёр банканд мэдэгдэж, мэдээллийг архивт бүртгэж хадгалдаг.</p>

Эх сурвалж: (Swift.com)

Хавсралт D Корреспондент банкаар дамжуулан төлбөр тооцоо хийх процесс

1. Төлбөрийн эхлэлт	Аливаа гадаад төлбөр эхлэх үед банк нь төлбөрийн хүсэлтийг хүлээн авна. Үүнд хүлээн авагчийн банкны болон корреспондент банкны мэдээллийг оруулна.
2. Корреспондент банкны сонголт	Илгээгч болон хүлээн авагчийн банкууд нь хоорондоо шууд холболтгүй байх тохиолдолд корреспондент банк ашигладаг. Корреспондент банк нь тухайн хоёр банкны хооронд дундын зуучлалын үүрэг гүйцэтгэж, гүйлгээг зохицуулдаг. Банкууд ныхэвчлэн өөрийн улсад байрлах корреспондент банкуудтай холбоотой байдаг бөгөөд үүнийг “Настро” болон “Вастро” данс ашиглан зохицуулдаг.
3. Мэдээллийн дамжуулалт	SWIFT систем ашиглан банк хоорондын санхүүгийн мэдээллийг аюулгүй нууцлалтайгаар дамжуулна. SWIFT мессежийн тусламжтайгаар гүйлгээний тухай мэдээлэл корреспондент банк руу дамждаг.
4. Гүйлгээний баталгаажуулалт ба боловсруулалт	Корреспондент банк нь төлбөрийн захиалгын мэдээллийг хянаж баталгаажуулсны дараа төлбөрийг хүлээн авагчийн банк руу шилжүүлнэ. Энэ үе шатанд валютын хөрвүүлэлт шаардлагатай бол корреспондент банк үүнийг зохицуулж, хүлээн авагчийн валют руу хөрвүүлнэ.
5. Хүлээн авагчийн дансанд хүргэх	Хүлээн авагчийн банк нь корреспондент банкнаас ирсэн төлбөрийн дагуу тухайн дансанд мөнгийг шилжүүлж, төлбөрийн дуусгалтыг хийдэг.

Эх сурвалж: (Санхүү, худалдааны банкны холбоо)

Хавсралт Е Монгол улсын гадаад төлбөр тооцооны гүйлгээний төрөл

Валют арилжаа	<p>2023 онд арилжааны банкуудаар хийгдсэн нийт валют арилжааны хэмжээ 10 тэрбум ам.долларт хүрсэн ба энэ нь жилийн өмнөхөөс 15%-аар өссөн байна.</p> <p>2023 оны эцсийн байдлаар Монгол Улсын гадаад валютын албан нөөц 4.9 тэрбум ам.доллар орчимд хүрсэн. Энэ нь өмнөх 3 жилтэй харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна. (Монголбанк, гадаад валютын улсын нөөц)</p>
SWIFT сүлжээ	<p>2023 оны байдлаар Монголын банкуудаас өдөрт 10,000 орчим гүйлгээ SWIFT сүлжээгээр дамжсан байна.</p> <p>Монгол Улсын нийт гадаад төлбөр тооцооны 85% буюу ойролцоогоор 8.5 тэрбум ам.доллар нь SWIFT сүлжээгээр дамжин хийгддэг. (Монголбанк 2023, SWIFT системээр хийгдсэн гүйлгээний статистик)</p>
Аккредитив	<p>Монголын арилжааны банкууд жилд дунджаар 2,500 орчим аккредитивийн гүйлгээ хүлээн авч, нийт дүн нь 500 сая ам.долларт хүрч байна .</p> <p>Импорт, экспортын компаниуд аккредитивийг түлхүү ашигладаг бөгөөд үүний 70% нь импортын төлбөрт зарцуулагддаг. (“Эдийн засаг бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв ,2020 “Банкуудын өрсөлдөөний тойм”)</p>
Инкасс	<p>Монголын нийт инкассын гүйлгээний хэмжээ жилд дундажаар 100 сая ам.долларт хүрдэг ба үүнийг Монголын томоохон банкнууд гүйцэтгэдэг. Инкасс нь хөдөө аж ахуй, уул уурхайн бүтээгдэхүүний худалдаанд өргөн ашиглагддаг.</p>

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэлээр

Хавсралт F“А” банкны SWIFT-ээр дамжуулан гүйлгээ хийсэн мэдээлэл (Сая ам. доллараар)

Он	Хүлээн авсан		Илгээсэн	
	Тоо	Гүйлгээний дүн	Тоо	Гүйлгээний дүн
2021	8500	246431.39	12287	256802.50
2022	7272	243037.79	11293	304123.73
2023	9085	679999.87	11381	574395.59
2024 (I улирал)	2132	319659.72	3049	260990.56
2024 (II улирал)	2100	287991.11	3385	234325.64
2024 (III улирал)	1985	191922.77	2880	76346.56

Хавсралт G Ярилцлагийн аргаар авсан арилжааны банкны гадаад гуйвуулга хийдэг улс (хувиар)

	БНХАУ	ОХУ	Бусад
Голомт банк	50%	30%	20%
Худалдаа хөгжлийн банк	60%	20%	20%
Хаан банк	60%	0%	40%
Хас банк	60%	0%	40%
Төрийн банк	50%	30%	20%
Тээвэр хөгжлийн банк	50%	20%	30%
Богд банк	50%	0%	50%
Ариг банк	20%	60%	20%
Капитрон банк	60%	0%	40%